

Засгийн газрыг огцруулах нь бидний гол зорилго биш

Хүчтэй сөрөг хүчин байхад анхаарлаа хандуулна. > 2

Түүхийн жимээр өртөөлөх уран бичлэг

Жүдогийн цэвэр ялалт шиг тухайн үеийнхээ сэтгэл хөдлөлийн эгшгийг буулгадаг. > 6



■ Мумбайн цэнхэр ноход бохирдлын гэрч болсон нь
■ Технологийн аваргуудад зохицуулалт хэрэгтэй

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын долдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- lkon.mn
- Caak.mn
- Xorom.com
- Zалуu.com
- Unuudur.mn
- Ubinfo.mn
- Medee.mn
- News.mn
- Eagle.mn

Эх сурвалж: Alexa.com ©



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.08.29, МЯГМАР ~ №162 (708)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Шадар сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх саналыг Ерөнхийлөгч буцаажээ.
УИХ-ын даргын зөвлөл хуралдаж, байнгын хороодын хуралдааны товгыг тогтоолоо.
Улсын төсвийн алдагдлын хэмжээг Үндсэн хуульд тусгах ёстой гэв.
Монгол, Японы гадаад харилцааны зөвлөлдөх уулзалт маргааш Улаанбаатарт болно.
Хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан шийдвэрлэх журмын төсөл боловсруулжээ.

ЭДИЙН ЗАСАГ

МИК-ийн цэвэр ашиг хоёрдугаар улиралд 18 хувиар өсөж, 36.1 тэрбум төгрөгт хүрэв.
"Prophesy Development" 888 мянган хувьцааг хаалттай хүрээнд гаргалаа.
ММС-ийн хувьцааны ханш нэг сарын хугацаанд 57 хувиар өсчээ.
"China Shenhua Energy" энэ оны хагаст ногдол ашиг тараахгүй.
BNP Billiton Канад дахь поташийн уурхайн 25 хувийг худалдана.

НИЙГЭМ

Өвөлжилтийн бэлтгэлийг ирэх сарын 15-ны дотор дуусгах үүрэг өглөө.
Улсын хэмжээнд 2696 гал түймэр гарч, 9.5 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.
Бөхийн өргөөний уулзвараар зүүн эргэх шийдвэр өнөөдрөөс хэрэгжинэ.
Багш нарын цалин нэмэгдүүлэх талаар судалгаа хийж байгаагаа салбарын сайд нь мэдэгдэв.
Хичээлийн шинэ жилээр 13 цэцэрлэг, 10 сургууль шинээр ашиглалтад орно.

ДЭЛХИЙ

Хятад улс БРИКС-ийн таван орныг ирэх сард болох дээд хэмжээний уулзалтад уриллаа.
Японы Окинава арлын захиргаа Америкийн Osprey онгоцны нислэгийг зогсоохыг шаардав.
Сөүл Пхеньянтай цөмийн асуудлыг яриа хэлэлцээрээр шийдвэрлэхээ мэдэгдлээ.
Энэтхэг, Хятад улс хилийн маргаантай Докламаас цэргээ холдуулахаар тохиролцжээ.
Техаст нефть боловсруулах гурван үйлдвэр хар салхины улмаас ажлаа зогсоосон байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.08.29



20° | 5°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 7 ДУГААР НҮҮРЭЭС ҮНШИНЭ ҮҮ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хотын замыг нөхөж барахгүй



Өнгөрсөн долоо хоногт үргэлжлэн орсон их бороо хотын замын чанарыг шалгаад амжлаа. Тав алхаад л тааралдах энхэл донхолтой зам жолооч нарын бухимдлыг төрүүлсээр байна. ▶5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН ГЭЭГДСЭН ҮНЭТ ЗҮЙЛ

Б.Баярмаа
@bayarmaa.boZGM

Монголчуудыг хэл сурахдаа авьяастай, хаана ч очсон аргаа олоод амьдарчихдаг гэж магтдаг. "Сохрын газар сохор, доголлонгийн газар доголтон" явах нь нүүдэлчин удамтай монголчуудын хувьд нийтлэг


чадвар бололтой. Гэвч энэ чадварын тун нь ихдээд ирэхээр эргээд хор болж байх шиг.

"Хөөгдчихгүй бол эргэж ирэхгүй" гэсэн урт хугацааны "виз"-тэй залуус жил бүр хэдэн зуугаараа хилийн дээс алхаж байна. Ер нь гадаадад сайхан, Монголд муухай гэсэн үзэл бидний тархинд шингэчихжээ. Ганц сар амьдарчихаад "Манай

Америк" гэж яриад шившгээ дэлгэж байсан бодит жишээ ч байна. Мэдээж ажилгүйдэл, ядуурал бол монгол залуусын гадагш "зугтаж" буй хамгийн гол шалтгаан. Гэхдээ үүний цаана бусдын соёлд хэт өртөмтгий, амархан уруу татагддаг байдал ч нөлөөлж буй.

▶3

ЗГМ: ИНФОГРАФИК



Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) ©

ЭДИЙН ЗАСАГ

Илч, гэрлийн эх үүсвэрийн үнэ өсөхгүй

Уурхайнуудад 1.2 сая тонн нүүрсний нөөц бэлэн байна

Г.Байгал

@baigalZGM

Хүйтний ам наашиллаа. Энэ өвөл олон жилийн дунджаас эрс хүйтрэхийг цаг уурын байгууллага анхааруулсан. Тэгвэл хүндэрч болзошгүй энэ өвөлд бид бэлэн үү. Эрчим хүчний яамны мэдээлснээр энэ өвлийн дулаан, цахилгааны хангамжийн бэлтгэл 70 хувьд хүрсэн байна. Ялангуяа, нийслэлийн бэлтгэл 78.2 хувьд

хүрээд буйг Нийслэлийн ЗДТГ мэдээлэв. Нийслэл, цаашлаад төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн систем нь Багануур, Шивээ-Овоо, Шарын гол уурхайгаас ундаалж, илч, гэрэл түгээдэг. Тиймээс эдгээр уурхайг нийслэлчүүдийн гал, голомт гэж болно.

Монгол Улсын нүүрсний хэрэглээний 60 хувь, эрчим хүчний нүүрсний 70 хувийг дангаараа хангадаг Багануурын уурхай наймдугаар сарын эцсийн байдлаар 600 сая тонн нүүрс олборлож, бэлтгэсэн байна. Тус уурхай энэ онд дөрвөн сая тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн ажээ.

▶11

АНУ, ОХУ-ын харилцааг Украин хордуулж байна

Роман Олейрчук

Украинд шинээр томилогдсон АНУ-ын тусгай элч Курт Волкер Украины хямралд шийдэл олохгүй бол Америк, Оросын харилцааг хордуулсаар байх болно гэжээ. Энэ нь Дональд Трампын засаглалын үед Москва харилцаагаа сэргээх найдварт цохилт боллоо. Ноён Волкер манай сонинд ярихдаа, АНУ-ын засаг захиргаа байр сууриа өөрчилж, Украинд зэвсэг нийлүүлэх асуудлыг нухацтай авч үзэж байгаа хэмээн онцлов. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жим Маттис өнгөрсөн долоо хоногт Украин хуучин Зөвлөлтөөс салж тусгаар тогтносны 26 жилийн ойн ёслолд оролцсон Ерөнхийлөгч Петро

Порошенкотой зэрэгцэн зогсож, Украиныг зэвсэглэх тухай мэдэгдсэн билээ. Ноён Волкер "Орос, Америкийн харилцаа чухал. Гэхдээ Украинаас болж доголдох байх" гэсэн юм. Тэрбээр Москва Украины зүүн нутагт энхийг тогтоох Минскийн гэрээг дагаж, тэндээс цэргээ гаргах талаар ул суурьтай шийдвэрт хүрэх ёстой хэмээн анхааруулав. Вашингтон түүнчлэн Киевийн зүгээс удтал хүсэж буй Оросын түрэмгийллээс хамгаалах, тогтоон барих зориулалттай зэвсэглэл нийлүүлэхийг судалж байгаа аж. Уг хүсэлтийг АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама няцааж байсан юм.

▶9

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
950.22 0.07%	1296.88 0.5%	6666 0.3%	96.950 0.03%	100.37 0.00%	2434.74	366.62	41.51

Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Засгийн газрыг огцруулах нь бидний гол зорилго биш

Хүчтэй сөрөг хүчин байхад анхаарлаа хандуулна

Б.Даваатогтох @datoZGM

УИХ дахь МАН-ын бүлгийн нэр бүхий гишүүд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах албан бичгийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Энэ талаар Ардчилсан намын дарга С.Эрдэнэс дарах зүйлийг тодрууллаа.

–Засгийн газрыг огцруулах саналд УИХ дахь Ардчилсан намын бүлэг ямар байр суурьтай байгаа вэ?

–Монгол Улсын нийгэм, эдийн засагт бодит дүгнэлт хийх хэрэгтэй байна. Хямралын уг үндсийг зөв тодорхойлох нь чухал. Үүнийг хэрхэн шийдэх вэ гэдэг л чухал болохоос аль нэг Засгийн газар огцрох, эсэх нь чухал биш. УИХ дахь Ардчилсан намын бүлэг ийм л байр суурийг баримталж байна. Эрх баригчид Засгийн газраа өөрчилж, солих нь тэдний дотоод асуудал. Бид өнөөдөр Засгийн газарт бус ард түмний эрх ашгийг яаж хамгаалах вэ гэдэг дээр санаа зовж байна. Хэд хоногийн өмнө УИХ-ын ээлжит бус чуулганыг хуралдуулах санал хүргүүлсэн. Харамсалтай нь, өнөөдрийг хүртэл хариу ирсэнгүй. Өвлийн бэлтгэлээ эртхэн хангахгүй бол зуд болох магадлал өндөр байна. Мөн бондын эргэн төлөлтийн асуудал ч сөхөгдөж эхэллээ. Уг нь өнөөдрийн төлөх гээд байгаа



Б.Ганбаяр / ЗГМӨ

өрийн хэмжээ тийм том асуудал биш. Манайх шиг байгалийн баялагтай улсад байдаг л өрийн хэмжээ. Гэвч байгалийн

баялагийн хуваарилалт шударга биш байна.

–Эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байгаа үед

Засгийн газрын тогтвортой байдал чухал гэдэг байр суурийг зарим улстөрч төдийгүй эдийн засагчид онцолж байна. Та

Бид өнөөдөр Засгийн газарт бус ард түмний эрх ашгийг яаж хамгаалах вэ гэдэг дээр санаа зовж байна.

үүнтэй санал нийлж байна уу?

–Аливаа Засгийн газрын талаар яриад эхлэхээр тогтвортой байдлын тухай асуудал хөндөгддөг. Сүүлийн долоо хоног хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр энэ талаар их ярилаа. Гэхдээ энэ асуудлаа эрт ярих ёстой байсан. Мэргэжлийн гэх тодотголтой Засгийн газар өнгөрсөн нэг жилийн хугацаанд юу хийв. Дандаа ард түмэн, сонгогчдын эсрэг үйл ажиллагаа явууллаа. Иргэдийнхээ эрх зүйн боломжийг нэмэгдүүлсэн нэг ч алхам хийж чадаагүй. Ерөнхийлөгчийн сонгуулиар ард иргэд Засгийн газрын үйл ажиллагаанд дүгнэлт хийлээ.

Ардчилсан намын хувьд аль нэг Засгийн газрыг огцруулах нь бидний гол зорилго биш. Үнэмлэхүй олонх байгаа нам Засгийн газраа хэд огцруулж, солих нь тэдний өөрсдийнх нь асуудал. Манай намын оролцоогүйгээр асуудлаа шийдэх эрх мэдлийг сонгогчид өгчихсөн. Энэ том эрх мэдлийг яаж удирдаж авч явах нь тэдний л асуудал. Харин манай намын хувьд нийгэм, эдийн засгийн зөв бодлого явуулаасай, зөв алхам хийгээсэй л гэж хүснэ.

–Дээрх асуудлын хүрээнд МАН-аас танаа намд яриа хийх санал тавьсан уу?

–Аль нэг Засгийн газрыг огцруулах асуудлыг баяртай хүлээж авах шаардлага бидэнд алга. Хүчтэй сөрөг хүчин байх, шүүмжлэлийг зөв явуулах тал дээр л бид анхаарлаа хандуулна. УИХ дахь Ардчилсан намын бүлэг энэ талаар хуралдана. Нэгдсэн байр суурь илэрхийлнэ. Одоогоор Ардчилсан нам болон УИХ дахь АН-ын бүлэгт ямар нэгэн санал ирээгүй байна. [ЗГМ]

Үндсэн хууль

Төсвийн алдагдлын хэмжээг Үндсэн хуульд тусгах ёстой гэв

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 21 аймаг, нийслэлийн есөн дүүргийн иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажил үргэлжилж байна. Тэгвэл ээлжит хэлэлцүүлэг Архангай, Булган болон Хөвсгөл аймагт боллоо.

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд “Манай улс түүхэндээ дөрвөн Үндсэн хууль баталсан бөгөөд цаг үеийн шаардлагаар Үндсэн хууль бүрт нэмэлт, өөрчлөлт оруулж байсан. Тухайлбал, 1924 оны Үндсэн хуульд нэг удаа, 1940 оны Үндсэн хуульд 16 удаа, 1960 оны Үндсэн хуульд 16 удаа, 1992 оны Үндсэн хуульд нэг удаа тус тус өөрчлөлт оруулсан.

Өдгөө хэрэгжиж буй Үндсэн хууль 25 жилийн хугацаанд төр, иргэний харилцааг зохицуулж ирсэн ч нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс үүдэн зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах зүй ёсны шаардлага үүссэн гэж олон нийт үзэн, үүний дагуу төсөл боловруулан бүх нийтээр хэлэлцүүлж байна” гэв.

Мөрөн сумын гуравдугаар багийн иргэн О.Баасанжав Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд алсын хараатай хандах нь зүйтэй хэмээн төслийн зарим зүйл, заалтыг дэмжиж буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн Үндсэн хууль нь хэл найруулгын өндөр түвшинд, монгол нэр томьёотой байх ёстой гэдгийг

анхааруулж, шүүгчид төдийгүй УИХ-ын гишүүний насны доод хязгаарыг 45 болгох нь зүйтэй гэдэг санал хэллээ.

АИХ-ын депутат асан Ц.Жамсран аливаа хууль бүхэн Монголын язгуур эрх ашгийг хамгаалсан байх нь чухал гэдгийг дурдаад УИХ-ын шийдвэр гаргах ирц дөрөвний гурав байх, УИХ-ын гишүүн хуралдаандаа тогтмол сууж төлөөллийн эрх, үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн хөшүүргийг Үндсэн хууль болон бусад хуульдаа тусгах шаардлагатайг хэлэв. Тэрбээр үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн, төрийн бодлогыг нэгтгэн зангидаж, хэрэгжилтэд хяналт тавьдаг, хариуцлага

тооцох эрх бүхий онцгой бүрэн эрхтэй төрийн захиргааны төв байгууллага байх, үүнийг Үндсэн хуульдаа үндсэн чиг үүргийн яам нэрээр тусгах санал гаргасан юм.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид “тосгон” хэмээх нэр томьёог оруулах нь оновчтой эсэхийг нягтлах, нийт иргэдийн эрх зүйн мэдлэгийг дэвшүүлэхэд анхаарах, улсын төсвийн алдагдлын хэмжээг Үндсэн хуульд тодорхой тусгах ёстой гэв. Мөн Засгийн газрыг тогтвортой ажиллуулах зохицуулалтыг тусгах, төрийн сүлдтэй холбоотой зүйл, заалтыг өөрчлөх, төрийн албыг тогтвортой, мэргэшсэн, улс төрөөс ангид болгох зорилгоор

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эргээд хүнд суртал дагуулах эрэдэлтэй эсэхийг нягтлах шаардлагатай гэсэн саналыг гаргав.

Дашрамд дурдахад, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг гурван үе шаттай явагдана. УИХ-ын Тамгын газраас орон нутагт бүсчилсэн сургалт, хэлэлцүүлэг явуулж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаар танилцуулж, гарын авлагаар ханган сургагч багш нарыг бэлтгэнэ. Бэлтгэгдсэн сургагч багш нар нь сум, баг бүртээ хэлэлцүүлгийн хоёр, гуравдугаар үе шатыг зохион байгуулах юм. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗАР

Хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан шийдвэрлэх журамтай болно

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг

Б.Тогтох ЗГМ

ЗГХЭГ-ын дарга, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дарга Ж.Мөнхбат Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзлаа. Тэрбээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого болон Засгийн газрын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны талаар танилцуулж, тэдний сонирхсон асуултад хариулав.

ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат

“Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн уналтыг зогсоох чиглэлээр авч буй арга хэмжээ, ОУВС зэрэг түнш байгууллага, орнуудтай үр дүнтэй хамтран ажиллаж буйгийн дүнд манай улсын эдийн засагт нааштай төлөв ажиглагдаж байна. Энэ оны хагас жилийн байдлаар 5.3 хувийн өсөлттэй гарсан. Мөн хөрөнгө оруулагчдын итгэл сэргэх хандлага ажиглагдаж байгаа. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг илүү тогтвортой болгох үүднээс “Хөрөнгө оруулагчаас төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын төсөл боловсруулж байна” гэв.

Харин БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хаймин Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж, уулзалт хийж, санал хүсэлтийг нь сонсож буй нь



zasag.mn

Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад анхаарч буйгийн тодорхой жишээ гэж үзэж буйгаа онцлов.

Хятадын хөрөнгө оруулагчид эрх зүйн орчин тогтворгүй

байгаа, зарим хуулийн заалт хоорондоо зөрчилддөг, төрийн байгууллагад гаргасан хүсэлт шийдвэрлэлт удаан, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, квот авахад хүндрэлтэй байгааг дуулгав.

Дашрамд дурдахад, өнөөдөр

ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат Монгол дахь Америкийн худалдааны танхимын уулзалтад оролцож, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, Зөвлөлийн үйл ажиллагааны талаар илтгэл тавих аж. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ

Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад санал буцаах тухай албан бичиг илгээлээ. Уг бичигт У.Хүрэлсүх Шадар сайдын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах болсон шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр зөвшилцөх шаардлагатай гэж үзэж байгаагаа дурджээ. Ингэснээр Засгийн газрын зүгээс Шадар сайдын өргөдлийг хавсаргаж, саналаа Ерөнхийлөгчид дахин илгээснээр зөвшилцөх бололтой.

» ПАРЛАМЕНТ

УИХ-ын даргын зөвлөл хуралдаж, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны лхагва гарагийн хуралдаанаар хэлэлцэхээр товложээ. Өнөөдөр УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаж, Шадар сайд болон Ерөнхий сайдаас тавьсан хүсэлтийг хэлэлцэх аж. Үргэлжлүүлэн УИХ дахь МАН болон АН-ын бүлэг хуралдаж, Засгийн газрыг огцруулах асуудалд байр сууриа нэгтгэхээр болжээ.

» УУЛЗАЛТ

Монгол, Японы гадаад харилцаа, аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын IV зөвлөлдөх уулзалт маргааш Улаанбаатар хотноо болно. Уулзалтаар Монгол, Японы Стратегийн түншлэлийн харилцааг улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарт бэхжүүлж, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх талаар ярилцана. Мөн олон улс, бүс нутгийн байдлын талаар харилцан мэдээлэл, санал солилцохоор төлөвлөжээ.

» ТОМИЛГОО

Ерөнхийлөгч Х.Баттулга захирамж гаргаж Ш.Адьяаг орон тооны бус зөвлөхөөр томилов. Гэхдээ түүнийг ямар салбарын зөвлөхөөр томилсон нь одоогоор тодорхойгүй байна. Ш.Адьяа нь Ховд аймгийн МоАХ-ны даргаар ажилладаг юм.

ЭШЛЭЛ



–МАН дотроо эвтэй, засаг дороо суурьтай байх нь Монгол Улсад ард түмэнд маань ус агаар шиг хэрэгтэй байна. Хар ухаанаар бодоход гэрээ гүйцэд барилгүй буурь сэлгээд байвал хүн малгүй зутарч, хөдөө хотгүй улдана биз дээ. Мөнхнаа гал тогоонд яриад шийдэж болох асуудлыг хэт дэвэргэж, гал дээр тос нэмэх хэрэг анхнаасаа байгаагүй. Эцсийн бүлэгтээ эндээс хэн ч хожихгүй. Хамтдаа зүтгэж, хамтдаа хөгжино гэж ард түмэндээ амлаж гарч ирчихээд өөр хоорондоо хагаралдаж үймэлдэх нь үнэндээ шал утгагүй шүү дээ. Улс гэрээ нурааж тоглох ямар хортойг өмнөх эрх баригчдын үед та бид хангалттай амссан. Тэр алдааг засаж, ачааг үүрнэ гэж итгэсэндээ л ард түмэн МАН-д 65 суудал өгсөн гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Сэтгэлгээний дархлаагүй учраас гаднын соёлд өртөмтгий байдаг

Японд очиход хэдийгээр орчин үеийн байшин, барилгууд сүндэрлэж байгаа ч цаанаа л үндэсний өв соёл, ахуй нь “үнэртэж” байдаг. Япон хүнийг азиудаас ялгах үнэт зүйл нь дэндүү хурц. Харин монголчуудыг бусдаас ялгадаг үнэт зүйл нь тийм гээд тоочих арга алга. Дэлхийг эзэлж байсан эртний түүхээ л ахин дахин ярихаас өөр зүйл бидэнд бий юу. Хэрэв хятад, орос, монгол гуравт яг ижил хувцас өмсүүлбэл бид юугаараа ялгарах вэ гэдэг сонин. Хятадуудыг суусан газраасаа шороо атгадаг гэдэг. Оросууд бол гүндүүгүй хэрнээ эмээж явбаас зохих хүмүүс гэж төсөөлөгддөг. Харин монголчуудад үзэсгэлэнт байгаль, баатарлаг түүх бий. Гэхдээ эд бол одоо цагт хувь хүн, үндэстнийг илэрхийлэх үнэт зүйлс биш.

Аливаа үндэстний бусад автахгүй байх сэтгэлгээний дархлаа тогтоодог “хамгаалагч” нь оюун санааны үнэт зүйлс болдог. Оюун ухаан сэтгэлгээний дархлаа нь бага балчраас аажмаар бэхэждэг онцлогтой. Гэтэл бид солонгос савангийн дуурь, америк супер баатруудаар хүүхдээ хүмүүжүүлж, гаднын соёлыг тахин шүтэгчдийг бойжуулж байна. Хоёр настнууд “ээж, аав” гэж биш “baby” гэж хэлд орж байна. Гадагш сургуульд яваад ирсэн залуус хоорондоо англиар ярьж, үүнийгээ боловсролтой хүний жишиг гэж үздэг болж.

Энэ жил монгол хэлний элсэлтийн ерөнхий шалгалтад 17 мянган сурагч хамрагдсанаас 11 мянга гаруй нь “F” үнэлгээ авсан. Гэсэн хэрнээ англи хэлний шалгалт өндөр үзүүлэлттэй



Манай үндэстний үнэт зүйлс гэж юу болох, хаана байна гэж дахин нэг асууя. Бид далан жил үргэлжилсэн социализмд нухчуулж, дараа нь зах зээлийн шуурганд бүдэчсээр үнэт зүйлээ хаа нэгтгээ гээчихжээ.

С.Цогтбаяр / ЗГМӨ

Гээгдсэн үнэт зүйл

гарсан байна. Хэл бол сэтгэлгээний хамгийн эхний цоожтой хаалга. Үр хүүхдээ “унаган” англи хэлтэй болгох хүслийн золиосонд төрөлх хэл маань шоовдорлогдоод байна.

Үндэсний үнэт зүйлсийг удирдагчид тээж явах учиртай

Арваад жилийн өмнө манайхан даяаршил гэгчийг оройн дээд шүтээн мэт дээдэлдэг байлаа. “Бид дэлхийтэй хөл нийлүүлэн алхах ёстой”, “Даяаршил бол хөгжлийн гүүр” гэх зэргээр их, дээд

сургуулийн багш нар улиглаж, улстөрчид пиар хийдэг байв. Харин өнөөдөр энэ үзэл явцуу байсныг гэрчилж, дэлхийн цөөнгүй орон даяаршлын өмнө хаалгаа янгинатал түгжиж, үүний оронд дангааршлыг илүүд үзэх болжээ. АНУ гэхэд л цагаачдаас нүүр буруулж, дэлхий нийтэд гэхээсээ илүү америк хүнд ашигтай, эсэхийг эхэлж хардаг болоод буй.

БНХАУ-ын хувьд кино урлагаар дамжуулан үндэстний үнэт зүйлээ тодотгож, сэтгэлгээний дархлаагаа бэхжүүлэх их аянд мордож, энэ нь ч үр дүнгээ өгч байна. Дотоодын уран бүтээлчдээ бодлогоор дэмжихээс гадна Холливудын том кино компаниудын хувьцааг эзэмших болсон. Хамгийн сүүлд гэхэд л эх оронч

залуугийн тухай өгүүлдэг “Wolf Warriors 2” кино нь 813.1 сая ам.доллар олж, бүх цаг үеийн хамгийн өндөр орлоготой 100 киноны жагсаалтад багтаж чадсан юм.

Гэтэл манайх эсрэгээрээ. МҮОНРТ жилийн өмнө БНХАУ-ын олон ангит кинонуудыг таван жилийн турш гаргах гэрээ хийсэн. Тухайн үед үндэсний аюулгүй байдалд халдлаа гэж эсэргүүцэж байсан хүмүүс өнөөдөр түүнийгээ аль хэдийнэ мартаж, киног нь үдэш бүр шимтэн үзэж байх жишээтэй. Уг нь монголчууд “хятад” гэхээр “Бид Чингисийн монгол” гээд цээжээ дэлдэж, өрвөлдөг хүмүүс. Тэгсэн хэрнээ зарим үед тахин шүтэх нь холгүй болох юм. Гэтэл үнэн хэрэгтээ сэтгэлгээний

дархлааны хомсдолд орсноос Хятадын “зөөлөн хүч”-нд ийнхүү “идүүлж” суугаа бус уу.

Манай үндэстний үнэт зүйлс гэж юу болох, хаана байна гэж дахин нэг асууя. Монгол хүнийг тодорхойлох боломж алга. Сэтгэлгээний дархлаа, үндэсний үнэт зүйлсийг улс орны удирдагчид тээж явдаг учиртай. Бидний хамгийн сайн мэдэхээр, танхайдуу хэрнээ эр зоригтой оросуудыг В.Путин илэрхийлж чадна. Зөвхөн өөрсдийгөө дэлхийн төв гэдэг АНУ-ыг Д.Трампаар төлөөлүүлж болно. Харин Монголыг хэнээр төсөөлөх вэ гэдэг бүрхэг. Дээл өмсөж, моринд мордохоороо монгол хүн болчихно гэсэн улстөрчдөөр л дүүрэн байх шиг. Уг нь тэд оюун санаа, сэтгэлгээний

луужин байх ёстой сон.

Монголчууд олон мянган жилийн турш эрс тэс уур амьсгалтай нөхцөлд, хоёр том гүрэнд уусалгүй оршоор ирсэн. Байгальтайгаа зөв харьцдаг, өв соёлоо үр хүүхдэдээ өвлүүлдэг, уламжлалт ёсоо дээдэлдэг нь үүний гол “түлхүүр” байлаа. Мэдээж, байгальтайгаа зөв харьцах гэдэг нь бүгд хөдөө гарч, мал маллахыг хэлэхгүй. Зөвхөн Монголд л яасан байгалийн хишгийг зөв зохистой ашиглаж, түүнийг мөхөөхгүй байх нь бидний үнэт зүйл. Хаана ч явсан уламжлал, өв соёлоо тээх нь сэтгэлгээний дархлаа юм. Гэтэл бид далан жил үргэлжилсэн социализмд нухчуулж, дараа нь зах зээлийн шуурганд бүдэчсээр үнэт зүйлээ хаа нэгтгээ гээчихжээ. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...

Та доорх кодыг уншуулж
Засгийн Газрын Мэдээ
Financial Times
сонинг нэг дороос уншина уу



Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131, 99903581, 99903584
info@zasag.co
Zasag.Co

Судлаачийн үг



Коммунист намын угшилтай учраас шинэчлэгдэж эс чадна



МАН-ын Бага хурал, Их хуралд хүргэх түүхэн сургаамж

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

2017 он Монгол ардын намын (МАН) хувьд түүхэн тэмдэглэлт, мартагдашгүй, ер бусын жил болж байна. Бүр стандарт бус жил. Их ялалт их ялагдал дагуулагд гэдгийг 2016, 2017 онд дараалаад ясанд нь тулгал ойлгуулчихлаа, энэ намд. Шинэчлэх тухай дахиад л яриад эхэллээ. БНМАУ-ын өөрчлөн байгуулалтын үзэс энэ намд шинэчлэл гэдэг үг дагалдаастай 30 жилийн нүүр үзлээ. Үргэлж яриад байсан юм бол тэрхүү шинэчлэл нь огт хэрэгжээгүй юм байна л гэсэн үг. Яасан ч барагддаггүй шинэчлэл вэ? Яагаад хэрэгжиж болдоггүй юм бол? Үүнд ганцхан л тайлбар байна. Тэр тухай дор хөндлөө.

“МАН хэзээ ч коммунист нам байгаагүй, одоо бол Социал-демократ бүрэн эрхт гишүүн”, “Ардын хувьсгал” байснаа дэлхийд данстай “Ардчилсан социалист” нам болж хувирсан гэхчлэн МАН-ын үе үеийн удирдлага цөхрөлтгүй ухуулах мөртлөө хэрэг болмогц, ялангуяа ахмад хижээл насны сонгогчдын санал дэмжлэгийг авах зорилгоор өмнөх коммунист түүхээ өөртөө авч наадаг нэгэн популист арга бачтай бид мэднэ. Коммунист түүхээ гээгээгүй, коммунист үзэл суртал, сахилгын арга барил, босоо тогтолцооноосоо огт салаагүй өнөөгийн МАН-ыг коммунист байгаагүй, коммунист биш гэж зөвтгөх нь нэн увайгүй, хүн чанаргүй хэрэг болохсон. Энэ тухай 1969 оны нэгэн баримт сөхөж, түүхэн үнэнийг сануулах гэсэн юм.

“Коммунист ажилчны намуудын олон улсын Москвагийн зөвлөлгөөн дээр МАХН-ын Төв хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын хэлсэн үг” хэмээх 16 хуудастай нэгэн товхимол 15 мянган хувиар хэвлэгджээ. Ю.Цэдэнбал энэ алдарт үгээ 1969 оны зургадугаар сарын 13-нд хэлсэн байх бөгөөд МАХН-ын Төв хороо

ба “Монголын коммунистууд”-ын нэрийн өмнөөс халуун баяр хүргэж эхэлсэн тэр үг Лениний мөнхийн сургааль, коммунизмын төлөө тэмцэлд үнэнчээ тунхаглан өндөрлөжээ.

Түүх рүүгээ эргэж нулимаах нь хаашаа юм, гэвч тэр үеийн империализм гэгчийг яллан гутааж, доромжлох нь энэ зөвлөлгөөний гол зорилго байсныг түүхээс баллуурдах аргагүй. Тиймдээ ч Ю.Цэдэнбал “империализмын эсрэг”, “империалистууд”, “империализмыг эсэргүүцэх”, “империалист харгислал” гэх хараалын үгийг 44 удаа давтаж, зарим өгүүлбэрт гурван ч удаа хэлсэн байх жишээтэй. Үүний сацуу өмнөд хөршөө “харгис маоизм”, “маоистууд”, “Маогийн бүлгийнхэн” гэхчлэн 35 удаа нэр зааж, бүтэн таван хуудас харааж зүхсэн байх юм. Тухайн цагтаа ингэж хараах нь зөв байсан ч өнөөгийн МАН, МАХН хоёр ардчиллын 27 жилд энэ түүхээ эргэж буруутгаагүй учраас “коммунист биш” гэдгээ эрх зүйн үүднээс нотлоогүй яваа гэсэн үг юм.

Дэлхийн коммунист хөдөлгөөний энэ чуулга уулзалт нь империализмыг эсэргүүцэн тэмцэх, эв нэгдлээ бэхжүүлэхэд дэлхийн коммунистуудын идэвхтэй хамтын ажиллагааны шинэ үе шат болно гэж бат итгэсэнэ Ю.Цэдэнбал илэрхийлээд, империализмын мөхөл ойртон, шалдаа буусныг олон баримтаар ярьсан байх юм. Ялангуяа “Америкийн империализм” гэдэг хаягаар АНУ-ыг муу муухай бүхний уурхай болгон харааснаа эргэж хүчингүй болгоогүй хэрнээ эдүгээ Монгол-АНУ-ын стратегийн нягт түншлэлийн тухай ярих нь түүхэн логикийн хувьд өөрөө өөртэйгөө зөрчилдсөн, өөрийгөө шууд үгүйсгэсэн хэрэг болох бус уу?

Ю.Цэдэнбалын хэлсэнээ ганц нэгийг эш татъя:

–Империалист харгислал нь хувьсгалт хүчинд түргэдэн шахагдахдаа арга буюу заль мэх хэрэглэн, ард түмэнд ад болсон дарлал мөлжлөгийн системийг хэвээр байлган бэхжүүлж...”, “империалистууд, юуны өмнө Америкийн империалистууд дэлхий дахины хувьсгалт үйл явцыг зогсоохын тулд...”, “империализм нь өдөөн хатгалга, хувьсгалын эсэргүү хуйвалдаан, харгис эргэлт, зэвсэгт довтолгоон зэрэг элдвийн арга хэрэглэн...”, “империализм нь дэлхийн системийн хувьд хүч нь нэмэгдээгүй ч гэсэн сүрхий аюултай дайсан хэвээр байна”, “империалист харгис гүрэн-АНУ-ын түрэмгий араншин ширүүслээ”, “империализмын хүч дампуурч, сөнөх тавилантай хамгийн тод гэрч бол Вьетнам дахь дайнд АНУ-ын түрэмгий төлөвлөгөө балран унасан явдал мөн” гэхчлэн



жагсаавал миний нэг нийтлэл гүйцэхгүй.

Ю.Цэдэнбал тэргүүтэй тэр үеийн МАХН, түүний авангард Төв хороо хожим эх орон нь хараал идсэн нөгөөх империалистуудаараа тэжээлгэн тэтгүүлэн чинээ огтоос төсөөлөөгүй. Гэвч МАХН-ын тэрхүү коммунист түүхийг МАН нь бүрэн эцэслэж, түүхэн дүгнэлт өгөх ёстой байсан юм. Үүнийг өнгөрсөн 27 жилд хийчихэж болох байсан ч залгамжлагч одоогийн МАН, түүнтэй өв булаацалддаг МАХН нь сонгогчдоо алдчихна гээд зориглоогүй. МАН нь МАХН гэсэн түүхэн коммунист нэр хаягаараа барууны донор хандивлагч гэгчидтэй хүзүү толгой холбон, империалист гэж хараасан барууны социалист, социал-демократ намуудтай нэг тугны иш барилцан явсан ба одоо ч тийм байгаа нь түүхэн логикийн хувьд мөн л өөр лүүгээ нулимсан хэрэг билээ.

Өнөөгийн хэмжүүрээр Ю.Цэ-

дэнбал ба түүний хэлсэн үгийг буруутгах гээгүй, зөвхөн коммунист байсныг нь сануулж байгаа хэрэг. Эдүгээ “Ардын хувьсгал”, “Социализмын байгуулалт”, “Ард түмнээ бичиг үсэгт тайлсан”, “Ардчиллыг эхлүүлсэн”, “Зах зээлийн шилжилтийн үеийг даван туулсан”, “Социалист интернационал” гэх зэрэг өөр хоорондоо авцалдаагүй түүхэн үзэгдлүүд нэг хаягтай, нэг өмчлөгчтэй явааг ялгаж салгаасай гэсэндээ 1969 оны ганцхан баримтыг сөхөж байна.

Ю.Цэдэнбалын хэлсэн тэрхүү үгэнд буй “Империализмын эсрэг тэмцлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг, капиталист орнууд дахь монополийн ноёрхлын үндэс тулгуурыг хэврэгшүүлэн сулруулж байгаа хамгийн идэвхтэй хүч нь ажилчны хөдөлгөөн юм” гэсэн мөрүүд нь Социал-демократ намуудыг хэлээгүй, харин тэдний эсрэг тэмцэгчдийг хэлсэн хэрэг байв. “Империализмын эсрэг

ангийн тэмцлийн шинэ их боломж бий болов” хэмээн Ю.Цэдэнбалын үнэлсэн тэр хөдөлгөөн эдүгээ ор мөргүй алга болсон. Харин яагаад тэгээ гэдэг онолын дүгнэлтийг ард түмэн 27 жил энэхүү намаас хүлээлээ. “Оппортунизм” гэдэг хаягаар 1980-аад оныг дуустал Социал-демократ намуудыг хараан зүхэж, баалж байснаа эргэж хүчингүй болгоогүйгээр дараагийн алхам руу шилжсэнийг өнөөгийн МАН-д сануулах нь ёс зүй, ёс суртахуун талаасаа огт буруу биш юм.

“Олон улсын коммунист хөдөлгөөний нэгдэл, нягтралыг бэхжүүлэх явдал нь империализмыг эсэргүүцэгч, ардчилсан бүх хүчнийг нэгтгэж, тэдний үйл ажиллагааг империализмыг эсэргүүцэх тэмцэлд идэвхжүүлэх үндсэн гол хүчин зүйл мөн” гэсэн Ю.Цэдэнбалын дүгнэлт бол коммунист хөдөлгөөнөөс бүх шавхрууг хөөж гарга гэсэн уриа дуудлага байв.

Империализмыг эсэргүүцэх

тэмцэл гэдэг бол оппортунизм, баруун, “зүүн” ревизионизмын эсрэг тэмцэл мөн гэсэн тэр үеийн МАХН-ын уриа эдүгээ Социал-демократ намуудыг зүхсэн хэрэг байв. “Монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнол болон шинэ амьдралын байгуулалтдаа олсон амжилт ялалтыг мөнхийн алдарт Лениний нэр, дэлхийн коммунист хөдөлгөөний бүх отрядын дайчин зэвсэг болсон Лениний аугаа их сургаальтай зүй ёсоор холбож үздэг юм” гэсэн андгай тангарагаар Ю.Цэдэнбал үгээ төгсгөөд, Лениний үзэл санаанд социалист Монголын намын гишүүд ба хөдөлмөрчид хойшид ч хязгааргүй үнэнч байж, марксизм-ленинизмын тунгалаг нандин чанарыг шийдвэртэй хамгаалах явдлыг МАХН өөрийн ариун үүрэг гэж үзнэ гэжээ.

1969 оныг хаагаад ардчилал шинэчлэл ид эрчээ авч байсан саяхны жишээг эшлээ. 1992 онд Хойд Солонгосын ард түмний аугаа их удирдагч Ким Ир Сений 80 насны ойн баярт уригдсан дэлхийн 132 орны 420 төлөөлөгч Пхеньянд хурал цугларч, ах дүү коммунист, хувьсгалт намуудын төлөөлөгчид “Пхеньяны тунхаглал” хэмээх түүхэн баримт бичгийг батлалцсан юм. Тэр үеийн эрх баригч МАХН-ыг төлөөлж нарийн бичгийн дарга нь тэрхүү тунхаглалд гарын үсэг зуржээ. Тунхаглалын гол үзэл санаа нь Дэлхийн хувьсгалын төв Солонгосын хойг руу шилжин төвлөрч, империализм өнөө маргаашгүй үхлээ хүлээн, мөхөл нь хаяанд ирсэн, даян дэлхийд хувьсгал, коммунизм ялан мандах нь гарцаагүй тухай уриа дуудлага ажээ. Энэ дуудлагаа МАН эргэж хүчингүй болгосон, гарын үсэг зурагчийг шийтгэсэн эсэхийг бүү мэд. Хэрэв түүндээ үнэнч яваа бол XXI зууны шинэ эринд Социал-демократ зүүн төвийн нам байгаагай нь эрс зөрчилдөн байгаа бус уу?

Энэ түүхээ эргэж буруутгаагүй учраас “коммунист биш” гэдгээ эрх зүйн үүднээс нотлоогүй яваа

Эндээс хийх ганцхан дүгнэлт бол өнөөгийн МАН шинэчлэгдэнэ, цэвэршинэ гэж хичнээн их ярих тусам тэр нь олон жилийн сунжирсан сул яриа болж, түүнд нь гишүүд дэмжигчид, монголчууд залхаж байгаа. Үүний гол шалтгаан нь МАН коммунист өвөөсөө бүрмөсөн татгалзаагүйн гай юм. 1990 оныг хүртэл нэг өөр нам байсан, тэр намын түүх БНМАУ-тайгаа, Сүхбаатар, Чойбалсан, Цэдэнбал, Батмөнхтэйгээ үүрд дууссан, 1990 оноор цоо шинэ, огт өөр нам үүссэн гэж зарлаагүйн гайгаар 27 жилийн турш шинэчлэх тухай ярьж байна. Бүр болохгүй бол 2010 онд МАХН-аа МАН болгон зарлаж байхдаа нэг түүхийг өндөрлүүлж, цоо шинэ нэг түүх эхэлж байгааг зарлачихсан бол шинэчлэл нь арай хялбараар цааш явах байсан бус уу?

Монгол ардын намын Шинэчлэлийн хороо, түүний Бодлогын зөвлөлд санал болгоё. Одоо намынхаа цоо шинэ түүхийг 2017 оноор эхлүүлчих!



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

[МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛААС ЧУХЛЫГ НЬ]

Фото сурвалжилга

Хуучин 22-ын товчооны ойролцоо "Номин" агуулах худалдааны төвийн өмнөх замын нэг урсгал нь бүхэлдээ эвдэрчээ. 2017-08-23.



С.Батсайхан / ЗГМӨ

Хотын замыг нөхөж барахгүй

36 тэрбум төгрөгөөр засварын ажил хийж байна

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Улаанбаатар хотын энд тэндгүй эвдэрч, цоорсон зам. Ганцхан жилийн өмнө тавьсан шинэ зам нэг өдрийн борооноор эмтэрч, машин явах аргагүй энхэл донхол болжээ. Бид хотын төвөөс баруун урагш гарч, Нарны зам, Үйлдвэр комбинат, Гурвалжингийн гүүр, 22-ын товчоо, 3, 4 дүгээр хороолол, Бөмбөгөр худалдааны

төв, Гандан гэсэн маршрутаар явж, хотын төвд эргэж ирсэн. Ингэж хотын баруун талыг бүтэн тойроход туслах болон төв замуудад таван алхам тутамд том, жижиг хэмжээний нүх, ан цав, хагарал үүссэн байлаа. Ердөө нэг, хоёр жилийн өмнө тавьсан шинэ замууд хэдийнэ эвдрээд эхэлжээ. Шинэ замууд эвдэрсэн байхад хэдэн арван жилийг элээсэн туслах замууд ямар байх нь ойлгомжтой биз.

Эвдэрхий замаас болж жолооч нарын тэвчээр ч барагджээ. Жолооч нарын авьяас, чадварыг сорьж буй хотын замуудыг засаж эхлэхгүй бол аваар, осол гарч, хүний амь нас эрдэх аюул тулгарч байгааг иргэд хэлж байна.

Иргэн Б “Мөргөлдөж осолдохгүйгээр хүрэх газраа дөхөж чадвал аз болно. Борооны улиралд байдал бүр ч дорддог. Учир нь борооны дараа зам дээр ус тогтчихоор нүх байгаа, эсэх нь харагддаггүй. Тиймээс зөөлөн явахгаас өөр арга байхгүй. Энэ нь замын түгжрэл үүсэх шалтгаан болдог” гэв.

Зам эвдэрч, үүнийг зохих хугацаанд нь засахгүй байна гэдэг ард түмний эсрэг их буугаар галлаж, зам дээр тэсрэх бөмбөг тавьсантай адил гэж гаднын оронд үздэг. Гэтэл манай хотын удирдлагууд яг борооны улирал эхлэхийг хүлээдэг үү, ямартай ч зун дуусаж, намар хаяанд ирэхэд зам засварын ажлыг эхлүүлдэг нь гайхмаар.

Зам засах нэрийдлээр энд тэндгүй том нүх ухчихна. Ингээд бороо орсны дараа ухсан нүхээ битүүлж, засах гэхээр өнөөх нь борооны усанд идэгдэж, төсөөлснөөс ч том болчихсон байдаг.

Түүнчлэн хувийн хэвшлийн хэн туслах замуудыг “будаа” болгож дууслаа. Нэг байшин барьчихаад кабелийн утас, шугам сүлжээ татах нэрийдлээр зам ухаж, сэндиичнэ. Дараа нь ухсан хэсгээ ямар ч норм стандартгүй, өөрсдийн дураар битүүлж орхино. Ингээд хэд хоногийн дараа, эсвэл борооны үеэр тухайн хэсэгт нүх, сүв үүсэж, иргэдийг хохироож байна. Энэ бүхэн хот төлөвлөлтгүй байдалтай шууд холбоотой.

Хотын хэдхэн хөндлөн замууд хаагуур байдаг, хэзээ ямар засвар хийх хэрэгтэйг тооцоолсон, бодсон хэн ч байхгүй. Зөвхөн аль нэг зам там болсны дараа, аль нэг гүүр эвдэрсний хойно сая нэг сэхээ орж, хааж, хорьж, боож, түгжихийг чухалчилдаг. Энэ талаар нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга Ж.Тогтохбаяраас тодруулахад “Улаанбаатар хотын 42 газарт том, жижиг нийлсэн зам засварын ажил өрнөж байна. Замын сангийн 36 тэрбум төгрөгөөр засвар, арчлалтын ажил хийгдэж байгаа. Гурван жил болоогүй эвдэрсэн замуудыг гүйцэтгэгч компаниуд, түүнээс олон жил болсныг нь Улаанбаатар зам, арчлалт компани хариуцаж

засна. Бороо ормогц л шууд очоод зам засах боломж байхгүй. Юуны түрүүнд нүх гарсан газар дээр очиж, зураг дарж баримтжуулан, тооцоо судалгааг нь хийж, захирамж гаргаж, тендер зарласны дараа ажлаа эхлүүлнэ.


Өнгөрсөн долоо хоногт орсон борооны улмаас нэлээд олон зам эвдэрсэн. Замын эвдрэл ямар хэмжээнд байгааг манай Мониторингийн хэлтсийнхэн газар дээр нь очиж, шалгана. Одоогийн байдлаар нөхөөс хийж байгаа төв болон туслах 60 гудамж, зам байгаа. Бид борооны дараа явж, тооцоо судалгаа хийсэн. Есдүгээр сар гараад зам нөхөх ажлууд эхэлнэ” гэв. [ЗГМ]



Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн баруун урд талын нүхэн гарц ашиглалтад ороод хоёр жил ч болоогүй байна. Гэтэл өнгөрсөн долоо хоногт үргэлжлэн орсон борооны улмаас их хэмжээний ус тогтож, том нүх үүсчээ. Жолооч нар нүх рүү орж, машиныхаа урд гүперийг эвдэх тохиолдол цөөнгүй гарч байна. Тиймээс ЗЦГ-аас өчигдөр зам хааж, засварын ажлыг эхлүүлэхээр боллоо.



Хонхойж эвдэрсэн зам автомашины дугуй, цаашлаад явах эд ангид халгаатай.



Эдэлгээ даадаггүй хурд сааруулагч замын эвдрэлд багагүй нөлөөлж байна.



6 дугаар бичил хорооллын туслах замууд үерийн усанд идэгдэж, замын хашилт нь урсан алга болжээ. Байр руу орж, гарах замаар автомашин байтугай явган хүн тээглэж унамаар бэрх.

Залуус

Түүхийн жиммээр өртөөлөх уран бичлэг



Б.Ганбаяр / ЗГМ©

Жүдо бөхийн цэвэр ялалт гэдэг шиг тухайн үеийнхээ сэтгэл хөдлөлийн эгшигийг буулгадаг

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Төрөлх хэл бичгийн соёлыг түгээн дэлгэрүүлж, муутуу цаасан дээр бийрийг “бүжиглүүлж” буй залууг Нямбаатарын Балжинням гэдэг. Тэрбээр каллиграф буюу уран бичлэгээр тав дахь жилдээ бүтээл туурвиж байна. Өдгөө олж авсан эрдэм мэдлэгээ бусадтай хуваалцахын сацуу уран бичлэгийг дэлгэрүүлэн судлахыг зорилгоо болгожээ.

-Уран бичлэгт хэзээнээс шимтгэх болсон бэ?

-Би Улаанбаатар хотын унаган хүү. Эхээс дөрвүүлээ. Айлын дундад хүүхэд. Гандантэгчинлэн хийдийн Шашны дээд сургуулийн Монгол зургийн ангид сурдаг. Манай сургууль бусад сургуулийн адил дөрвөн жил сураад бакалаврын зэрэг эзэмшдэг. Харин каллиграф буюу уран бичлэгийн төрлөөр хичээллээд таван жил болж байна. Миний бийрийн титмийн багшийг Э.Эрдэнэ-Зуу болон Б.Алтантуяа гэдэг. Манж, Төвд хэл судалдаг болохоор ч тэр үү хэл бичигт их сонирхолтой. Тиймээс л уран бичлэгээр бичиж эхэлсэн. Гэр бүлийнхэн болон лам багш нар маань их тус болсон. Одоо урландаа сургалт явуулж, хүмүүст уран бичлэг зааж байна.

-Өдөрт хэчнээн цаг сургуу-

лилалт хийдэг вэ. Хичээлийн хажуугаар энэ бүхнийг амжуулахад хүндрэлтэй байдаг уу?

-Өдөрт хамгийн багадаа хоёр цаг сургуулилалт хийхгүй бол гар эвлэхээ больчихдог. Тиймээс өдөр бүр сургуулилалт хийнэ. Заримдаа цаг зав гарахгүй үедээ баримлын шавар атгаад явдаг. Учир нь гараа уян хатан байлгахын тулд ийм дасгал хийнэ. Харин хийх ажлаа уридчилан төлөвлөдөг учраас бэрхшээл гардаггүй. Ерөнхийдөө энэ бүгдийн цаана ээж минь байдаг гэхэд хилсдэхгүй. Миний найдвартай ар тал шүү дээ (инээв).

-Хэл бичгээ сайн мэддэг байхаас гадна гарын эв дүй их чухал байх?

-Тэгэлгүй яахав. Монгол бичгийг сайн мэддэг байж, уран бичлэгт буулгадаг. Уран бичлэгээр бичихэд гарын эв дүй чухал. Бийрийн барилт, өргөлт, таталт, цаастайгаа хэрхэн харыхах зэрэг нарийн ажиллагаа ихтэй. Мөн нарийн мэдрэмж шаарддаг. Товчхондоо анхаарлаа сайн төвлөрүүлэх шаардлагатай гэсэн үг. Тэгж байж нэг удаагийн татлагаар бичнэ шүү дээ. Уран бичлэгийг ямар ч хүн сурах боломжтой. Хамгийн гол нь тууштай, хичээл зүтгэлтэй байх хэрэгтэй.

-“Улаанбаатар принт”-ээс гаргадаг дэврийн хавтсыг өөрийн тань бүтээл өнгөлөх болжээ. Энэ тухайгаа ярихгүй юу?

-Өнгөрсөн долдугаар сард хамтран ажиллах санал тавьсан. Ингээд оюутан, сурагчдад зориулсан, урам өгөх зорилготой найман төрлийн уран бичлэг гаргахаар болж, бэлтгэл ажлаа хангаж эхэлсэн. Энэ сарын 20-доор хэвлэлтээс гарч, хүмүүсийн гар дээр хүрсэн байх. Цаашид өөр олон цуврал

гаргахаар төлөвлөөд байна.

-Зураач хүн уран бичлэгээр бичихэд илүү ойр байдаг уу?

-Зураг зурдаг хүн каллиграф бичихэд их дөхөм байдаг. Би гэхэд өөрийн ур дүй дээрээ үндэслэн сонирхолдоо хөтлөгдөн уран бичлэгээр бичиж байна. Миний бичлэг бол эртний судрууд дээр байдаг шиг хэв маягаа олсон, тогтуун тайван өнгө аяс агуулдаг. Одоо ч бүр гүн орж байх шиг байна даа (инээв).

Өдөрт дор хаяж зургаан цаг огт хөдлөхгүй сууж сурдаг

-Уран бичлэгээр бичдэг хүмүүсийн нэрийн хуудас нь тамга байдаг шүү дээ. Өөрийн бичлэгэд тамганыхаа талаар ярихгүй юу?

-Бичээч хүний дөрвөн эрдэнэ гэж байдаг. Үүнд бийр, бэх, муутуу цаас, янтай гэж бий. Бичээч хүний нэрийн хуудас болох тамга нь юу ч байж болдог. Тухайлбал, эмэгтэй хүмүүс цаа буга, янз бүрийн хээ хураар тамгаа хийлгэсэн байдаг. Ихэвчлэн монгол дөрвөлжин үсгээр нэрээ бичдэг. Харин минийх соёмбо болон дөрвөлжин үсгээр нэрээ бичсэн хоёр тамга бий.

-Өөрийн тань урын санд хэчнээн бүтээл байдаг вэ?

-Хүний нэрнээс авахуулаад эртний түүх, шүлэг гээд их олон төрлийн зүйл бичдэг. Миний тооцоолсноор айлын хойморт залсан 500 орчим, сорчлон бүтээсэн таван уран бичлэг бий. Би 2015 оны арванхоёрдугаар сард Ерөнхийлөгчийн нэрэм-

жит “Хүмүүн бичиг”, 2016 онд Монгол туургатны “Миний монгол бичиг” тэмцээнд оролцож түүрүүлсэн. Мөн 2015 онд “Болор цомын шүлгийг босоо монгол бичгээр” тэмцээнд орж, эхний тавд шалгарч байсан.

-Уран бичлэгээр бичихэд хэр хугацаа зарцуулдаг вэ?

-Нэг бичээд эхэлчихвэл хэдэн цагаар ч хамаагүй суучихдаг. Гэхдээ яг бичих хугацааны хувьд жүдо бөхийн цэвэр ялалт гэдэг шиг тухайн үеийнхээ сэтгэл хөдлөлийн эгшигийг буулгадаг болохоор маш богино хугацаанд бичдэг. Харин нэг алдаа гаргавал эргэж засах боломж байдаггүй.

-Хэдэн ч цагаар хамаагүй бичээд суучихдаг гэсэн. Каллиграфтаар бичихийн юу нь сайхан байдаг вэ?

-Урлагийн их мэдрэмжтэй болгохын сацуу тэвчээртэй болдог. Тухайлбал, гурав, дөрвөн метр урт судар бичиж байхад хүний тархи, нүд, бугуй, хуруу, тохой бүгд зэрэг ажилладаг. Тиймээс анхаарлаа төвлөрүүлэх нь хамгийн чухал.

● **Гараа уян хатан байлгахын тулд баримлын шавар атгаад явдаг.**


● **Бийрийн барилт, өргөлт, таталт, цаастайгаа хэрхэн харьцах зэрэг нарийн ажиллагаа ихтэй.**

● **Оюутан, сурагчдад зориулж найман төрлийн уран бичлэгтэй дэвтрийг Улаанбаатар принттэй хамтран гаргаад байна.**

Өдөрт дор хаяж зургаан цаг огт хөдлөхгүй сууж сурдаг. Сэтгэл санаа тогтвортой болно. Зарим хүн каллиграф бичиж байгаад монгол зураг зураад сурах нь ч бий. Энэ бүгдийг харж, уншиж, бичиж, мэдэрч байна гэдэг л хамгийн сайхан нь шүү дээ. Цаашид төвөд, тод монгол бичгээр бичиж үзнэ гэж бодож байгаа. Мөн монгол зургийг ч каллиграфтаар зурж үзэх санаа бий.

-Сургалтаа хэрхэн зохион байгуулдаг вэ?

-Урландаа уран бичлэгээ бичихээс гадна хүмүүст сургалт явуулж байгаа. Сургалтад маань морин хуурч, гитарчин, яруу найрагч, бизнес эрхэлдэг гээд янз бүрийн хүмүүс явдаг. Олон хүнд заахад хүндрэлтэй байдаг учраас 5-10 хүнд заадаг. Улаанбаатар хотоос гадна хөдөө орон нутагт хэдэн удаа очиж сургалт явуулж байсан. Тухайлбал, Булган, Завхан аймгийн багш нарт 3-30 хоног хүртэлх хугацаагаар сургалт явуулсан. [ЗГМ]



ХӨТӨЧ

Чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тохиромжтой газрууд

Сүүлийн жилүүдэд залуучууд найз нөхөдтэйгөө ярилцаж, чөлөөт цагаа өнгөрүүлэхдээ кофе шопыг зорих нь ихэссэн. Тэгвэл үүнээс гадна хичээл хийх, утсаар ярих, цахим орчноор чөлөөтэй аялах боломжтой, гэртээ байгаа мэт тухлаг орчин бүхий газруудыг танилцуулж байна.



ZIFERBLAT MONGOLIA

Нийслэл хотод нээлтээ хийгээд хагас жил болж байгаа ч аль хэдийнэ залуучуудын очих дургуй газар болжээ. Энд балчир хүүхдээс эхлээд ахмад настан гээд бүх хүнд нээлттэй орон зай олгодог. Орж ирсэн хэн

боловч аваад унших боломжтой ном зохиол, сонин сэтгүүл, хүүхдэд зориулсан номын сан, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоос гадна цонхны тавцан, булан, буйдхан зэрэг хэн ч очоод суух боломжтой өвөрмөц шийдлийг гаргажээ. Дэлхийн өнцөг булан

бүрт салбартай, суусан минутаар нь төлбөрөө төлдөг чөлөөт цагаа өнгөрүүлэх хөгжлийн төв аж. Нэг үгээр хэний ч талаар, юу ч хамаагүй бичмээр газар. Энд зураг зурах бүх хэрэгслүүд бэлэн, хэрэглэхэд үнэгүй байдгаараа онцлог юм. Мөн гитар, төгөлдөр хуур тоглох ч боломжтой.

Ажиллах цагийн хуваарь: Даваа-Ням 10.00-22.00

Холбоо барих утас: 9811-0984

BEE CAFE

Энд нийтийг хамарсан төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг бөгөөд мягмар гаригт англи хэлний ярианы



клуб явуулдаг онцлогтой. Интернет номын дэлгүүртэй хамтран ажилладаг болохоор та сонирхсон номоо түрээсээр авах боломжтой.

Ажиллах цагийн хуваарь:

Даваа-Ням 7.00-22.30

Холбоо барих утас: 8807-7311

GESU ART STUDIO

Хүрэлцэн ирсэн хэн бүхнийг итали, бразил кофе хүлээж байх болно. Энд ихэвчлэн жааз, төгөлдөр хуурын уянгын аялгуу эгшиглэнэ. Нэг үгээр хэлбэл, хосуудад зориулсан таатай орчин энд бий. Уран зургаар орчноо

чимэх тус газар өглөөний хөнгөн хоол зуушаар үйлчлэх бөгөөд бямба гарагт уран зургийн хичээл явуулдаг аж.



Ажиллах цагийн хуваарь:

Даваа-Ням 9.30-20.00

Холбоо барих утас: 11-326368

Лавлах

ХӨТӨЧ Бөхийн өргөөний уулзвараар зүүн эргэнэ



З.Цэлмэг
ЗГМ

Төв зам дагуу хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгс-
лүүдийг өнөөдрөөс эхлэн Бөхийн
өргөөний уулзвараар зүүн эргэ-
хийг нийслэлийн удирдлагууд
зөвшөөрчээ.

Энхтайваны өргөн чөлөөний
долоон уулзварт зүүн эргэхийг
хориглосон шийдвэрийн үр
дүнд төв замын хөдөлгөөний
ачаалал буурсан ч бусад замынх
эрс нэмэгдсэн. Ачаалал ийн эрс
нэмэгдэж буйг харгалзан нийс-
лэлийн удирдлагууд өнгөрсөн
долоо хоногт Бөхийн өргөөгөөр
зүүн эргэдэг болох боломжийг
судалж үзэхийг холбогдох алба-
ныханд үүрэг болгосон юм.

Хотын дарга даваа гарагт
мэргэжилтнүүдийн дүгнэлт,
саналыг үндэслэн Энхтайваны
өргөн чөлөөнөөс Токиогийн
гудамж руу зүүн эргэх хөдөл-
гөөнийг өнөөдрөөс нээхээр
болжээ. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД Дурангийн мэс засал үнэгүй хийнэ

М.Мөнхзул
ЗГМ

“Глобал грант” төслийн
хүрээнд БНЭУ-аас 16 хүний
бүрэлдэхүүнтэй мэс заслын эмч
нарын баг наймдугаар сарын
28-наас есдүгээр сарын 8-ны
хооронд ажиллахаар хүрэлцэн
ирлээ.

Энэтхэг эмч нар Улсын гурав-
дугаар төв эмнэлэгт мэдрэлийн
мэс засал, дурангийн мэс засал,
мэдээгүйжүүлэлт, ЭХЭМҮТ-д
чих, хамар, хоолойн чиглэлээр,
ГССҮТ-д гар сарвуу болон
түлэнхий мэс заслын тасагт,
Амгалан амаржих газарт
дурангийн мэс заслыг үнэ
төлбөргүйгээр хийж, сургалт
зохион байгуулах юм. Мөн
Хавдар судлалын үндэсний
төвд өвчтөний асаргаа, сувилгаа,
эмчилгээний чиглэлээр танхи-
мын болон ажлын байрны багц
сургалтуудыг зохион байгуу-
лахаар болжээ. [ЗГМ]

НИЙТИЙН ТЭЭВЭР Цахим картаа амжиж захиалаарай

Их, дээд сургуульд шинээр
элсэж буй оюутнууд энэ сардаа
багтааж цахим карт авах мэдүүлэг
бөглөж өгөх шаардлагатайг
албаныхан анхааруулж байна.
Тухайн сургууль оюутнуудын
мэдүүлгийг нэгтгэж, нийслэлийн
Боловсролын газарт энэ долоо
хоногтоо багтан хүргүүлэх
юм. Улмаар цахим картыг
идэвхжүүлж, есдүгээр сарын
1-5-ны хооронд сургуулиуд
өөрсдийн байранд олгоно.
Хэрэв өмнө нь ашиглаж байсан
цахим картаа үрэгдүүлсэн бол
есдүгээр сарын 1-8-ны хооронд
сургуулийнхаа Сургалтын алба,
Оюутны холбоонд хүсэлт гаргах
хэрэгтэй юм байна. МСҮТ,
коллежийн 13 мянга гаруй
оюутан их, дээд сургуулийн
адил гурван шатлалаар картаа
захиалах юм. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Петровка-38” Оросын УСК 7, 8 дугаар анги	07.30 “Амжилтад хязгаар үгүй” нэвтрүүлэг	08.10 “Анхдагчид” хүүхэддэйн кино 51, 52 дугаар анги	06.30 Өнөө өглөө
12.00	12.45 Шинжлэх ухааны 10 хором: Мэдрэлийн эс	11.35 “Байршил” нэвтрүүлэг	11.15 “Харваач” ОАК 2.8 дугаар анги	12.00 Хөтөч мэдээллийн хөтөлбөр
14.00	14.00 “Цэлмэг” өдрийн хөтөлбөр (шууд)	14.00 “Чарли Роузын ярилцлага” нэвтрүүлэг	14.10 “Хүрээлэн” амьд ертөнц нэвтрүүлэг /цуврал 81/	15.30 “Оёдлын газрын боловсон эрчүүд” ОАК 21 дүгээр анги
18.00	18.20 “Амьдрал чиний төлөө” ОАК 27 дугаар анги	18.00 “Бизнесийн төв цэг” давталт	18.05 “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэддэйн кино	17.30 “Хүчирхэг ренжерүүд” хүүхэддэйн кино 13, 14 дүгээр анги
20.00	19.25 Урлаг теле сэтгүүл	20.00 “Made in Mongolia: Гялс ХХК” нэвтрүүлэг	20.45 Дэлхийн санхүүгийн түүхүүд	19.30 “Ороод гараач” нэвтрүүлэг 33 дугаар хэсэг
22.00	21.45 Засгийн газрын цаг	22.00 “Эзэнт гүрнийг босгосон нь” нэвтрүүлэг	22.10 “Гурван найз” ОАК 3, 4 дүгээр анги	22.30 “Тэрслүү хөвгүүд” ОАК (season 5) 8 дугаар анги

ОНЦЛОХ ҮЗВЭР “Есдүгээр сарын 1”



Үндэсний соёл амралтын
хүрээлэнд 2017-2018 оны
хичээлийн шинэ жилийн нээлтэд
зориулсан анхны шоу тоглолт
болох гэж байна. Уг тоглолтод “The
Lemons”, “A sound” хамтлагуудаас
гадна дуучин Б.Маралжингоо,
М.Номин-Эрдэнэ, С.Зоригт,
А.Хишигдалай нар оролцоно. Мөн
Dj BTB Anna, Миусгii зэрэг уран
бүтээлчдийн сэтгүүдээс сонсоорой.
Есдүгээр сарын 1-нд ганцхан
өдөр болох уг тоглолтын энгийн
тасалбар 9000 төгрөг. Харин тусгай
суудал бүхий тасалбар 15 мянган
төгрөгийн үнэтэй. Мөн 15 мянган
төгрөгийн багцын тасалбараар
гурван хүн үзэх сонголт ч байгаа
аж. “Есдүгээр сарын 1” тоглолтыг
ямар ч насныхан үзэх боломжтой
гэдгийг зохион байгуулагчид
онцлолоо. [ЗГМ]

ҮЗВЭР

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙ

Чойжин ламын сүм музей
Улаанбаатар чуулгатай
хамтран “Шөнийн сүм музейд
Улаанбаатар чуулга” үдшийн
цэнгүүнийг зохион байгуулах
гэж байна. Энэхүү арга хэмжээнд
хүрэлцэн ирснээр Монголын
түүх соёлын үнэт өв болох
Чойжин ламын сүм музейн
арвин баялаг сан хөмрөг, хосгүй
үнэт бүтээлүүдийг үзэж, мэлхий
баясгахын зэрэгцээ Улаанбаатар
чуулгын нийт уран бүтээлчид
болон Хангарьд найрлын
тоглолтыг үзэж, сонирхох
боломжтой юм. Тоглолт ирэх
сарын 7-ны 21.00 цагт болно.

БӨХИЙН ӨРГӨӨ

Нийтийн дууны шилдгүүд
нэгдэж “Мартагдашгүй намар”
тоглолтыг үзэгчдэд толилуулах
гэж байна. Тоглолт есдүгээр
сарын 1-ний 19.00 цагт Монгол
бөхийн өргөөнд болно. Тоглолтыг
Ddish Live 900 тусгай төлбөрт
сугаар үзэж болох юм.

UB COMEDY CLUB

Алдартай телевизийн
нэвтрүүлгүүдэд өөрийн
шог үзүүлбэрээр оролцсон
АНУ-ын иргэн Адам Хантер
Улаанбаатарын хошин шогийн
клубийн тайзнаа тоглоно.
Дэлхийн хэмжээний Stand Up
тоглолт энэ сарын 31-нд 20.00
цагт болно.

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Залууст зориулсан “Be... Live
show 2017” тоглолтыг ирэх сарын
9-нд хоёр дахь жилдээ зохион
байгуулна.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 8

Намрын тэргүүн шар бич сарын
дөрвөн ногоон мэнгэтэй шар
хулгана өдөр
Үс засуулбал: Нас уртасна.
Наран ургах, шингэх: 06.10-19.39
Барилдлага: Түлэх
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй
Суудал: Үс

Аргын тооллын наймдугаар

**сарын 29, Ангарга гараг. Билгийн
тооллын 8. Онгоц одтой, шар
хулгана өдөр.**

Өдрийн наран 06.10 цагт мандан,
19.39 цагт жаргана. Тухайн өдөр луу
жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг
сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу
нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай
хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл
өдөр гэмтнийг шийтгэх, лус тахих,
хүүхэд үрчлэн авах, хур оруулах,
дарханы үйлд сайн. Улааны үйл, төлөг
тавих, морь уралдах, сэтгэлд сэвтэй
газар очиход муу. Өдрийн сайн цаг
нь хулгана, үхэр, туулай, морь, бич,
тахиа болой. Хол газар яваар одогсод
зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс
шинээр үргээлгэх буюу засуулбал нас
уртадна.


ГАЛТ ТЭЭРГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Бээжин-Москва	07.45	14.28
Москва-Бээжин	21.35	14.31
УБ-Москва	13.50	14.28
Москва-УБ	21.35	07.30
Эрээн-УБ	18.00	11.15
УБ-Эрээн	20.00	10.25
УБ-Бээжин	07.15	14.04
УБ-Хөх хот	20.00	20.49
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Бээжин-УБ	01.40	04.10
УБ-Хонконг	06.25	10.55
УБ-Токио	07.55	13.40
УБ-Сөүл	08.45	12.50
Хонконг-УБ	12.05	16.45
Сөүл-УБ	14.20	16.50
Токио-УБ	14.40	19.10
УБ-Бээжин	17.55	20.10
Бээжин-УБ	21.10	23.40
УБ-Ханбумбат	20.00	21.10
Ханбумбат-УБ	22.00	23.05

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- | | | |
|------------------------------------|---|----------------------------|
| 2. Гурван мэргэдийн
нэг мэргэд | байрлах зүйл | хүндэтгэн өгсөн нэр |
| 3. Баяр наадмын
талбайн хойморт | 4. Эрэлхэг зоригт,
улаан цэргийн
жанжин Шетинкинд
монголчуудын | 5. Уурын зуухны
ажилчин |
| | 8. Үржил шимгүй
элсэрхэг газар | |



9. АНУ-ын
Ерөнхийлөгч
Д.Трампын нам
(товчилсон нэр)
12. Хөлбөмбөгийн
хаалганд орсон
бөмбөг
13. Индонезийн
мөнгөний нэгж
ХӨНДЛӨНГӨӨР:
1. Хойд Америкийн
мэргэжлийн
хоккейн лиг
(НХЛ)-д элссэн
Оросын анхны
легионеруудын нэг,
хоккейн од
4. Орон сууцны
зарим цонхны
гаднах зүйл
6. Улсын филармони
зэрэг соёл урлагийн

- байгууллагууд
байрладаг
томоохон
концертын заал
бүхий соёлын төв
(товчилсон нэр)
7. Байлдааны
онгоцны нэгэн
төрөл
10. Тасалгаа
11. Сайн үйл
12. Гурвдугаар
гэсэн үг
14. Ососор бич
15. Адуу малын зүс
16. АНУ-ын алдарт
суудлын авто-
машин Роллс.....

Өмнөх дугаарын хариу / 08.28



ЦАГ АГААР



ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН.....

Манай оронд 357 зөвшөөрөгдсөн хогийн цэг байгаагийн зөвхөн 68 нь хог хаягдлыг хөрсөөр дарж устгадаг бөгөөд бусад нь ил задгай хаядаг. Аюултай хог хаягдлыг улсын хэмжээнд тооцож үзвэл, жилд 29-58 мянган тонн байхаар байна.

НOMADIC COMICS

Байршил



ОЛИМПИК
РЕЗИДЕНС

Холбоо барих



9908 9950

9907 6880

9906 1667




www.olympic-residence.com



[/theolympicresidence](https://www.facebook.com/theolympicresidence)



Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Олимпик
Резиденс



Престиж Оффис

Монголиан Пропертис компанийн 5 дахь оффис
@ Олимпик Резиденс



● Монголиан Пропертис компанийн
Престиж оффис

● Монголын Урлагийн Зөвлөлийн
“Улаан гэр” арт галерей

худалдаа үйлчилгээ, орон сууц хосолсон
Олимпик Резиденс цогцолборт нээгдлээ.

9908 9950, 9907 6880, 9906 1667



Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж, Олимпик Резиденс



www.olympic-residence.com



[/theolympicresidence](https://www.facebook.com/theolympicresidence)

Онлайн бичлэгийн эздийг хянах алхам

Хятадын интернэт компаниуд хэрэглэгч нарынхаа хэн болохыг тодорхойлж байх үүрэг хүлээв. > 10

Тереза Мэй хэт өндөр цалинтай боссуудын эсрэг тэмцэнэ

Зарим захирлын үйлдэл бизнест итгэх итгэлийг алдагдуулж байгааг ерөнхий сайд шүүмжлэв. > 10

Энэтхэгийн татварын шинэ тогтолцоонд бэрхшээл үүслээ

Шинэ тогтолцоонд үүссэн бэрхшээл ноён Модигийн эдийн засгийн шинэчлэлд сөрөг нөлөөтэй. > 10

АНУ, ОХУ-ын харилцааг Украин хордуулж байна

Америкийн тусгай элч цааш нь “Трампын захиргаа одоо Обамагийн няцаалтыг үргэлжлүүлэх өөрчлөх эсэхээ судалж байна. Шинэ шийдвэр одоогоор гараагүй. Гэхдээ өндөр албаны хүмүүс нухацтай авч үзэж байгаа. Мэдээж шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана” хэмээв. Волкерын энэхүү тайлбарыг Трампыг сонгогдсоны дараа Вашингтонтой харилцаагаа сайжруулахыг найдаж байсан Москва таатай хүлээж авсангүй. Трампын захиргаа Украины асуудлаар илүү нааштай байр суурь баримтлах буюу хойш тавина гэж Кремль итгэж байв.

Гэтэл ноён Волкер ярихдаа Вашингтоны анхаарал Украинаас хөндийрч, Трампын захиргаа Герман ба Францын хамт асуудлыг буцаан хөндөж байгаа тухай тэмдэглэжээ. Тэрбээр “Мөргөлдөөн хурцдах түгшүүр нэмэгдэж байна. Бид ямар нэгэн зүйл хийхгүй бол улам муудах байх” хэмээн дүгнэсэн байна. МкКэйний хүрээлэнгийн захирал агаад НАТО-д АНУ-ын Элчин сайдаар сууж байсан ноён Волкер Украины зүүн нутагт 10000 орчим хүний аминд хүрсэн байлдааны талаар Москвагаар

хийх хэлэлцээрт Европын удирдагчдыг дэмжих зорилгоор томилогдсон юм.

Тэрбээр Украины асуудлаар Оросын төлөөлөгч Владислав Сурковтой эхний уулзалт хийснийхээ дараа “Орос улс үргэлжилж буй мөргөлдөөнд зохицохоор бэлтгэсэн бололтой. Миний бодлоор энэ нь тэдний хувь гарц биш. Оросууд Донбассын хэрэгт оролцсоныхоо төлөө олон улсын зүгээс хохирол амсаж, улс төрийн хоригт бас өртсөн. Цаг улирах дутам нөхцөл байдал муудна уу гэхээс сайжрахгүй нь ойлгомжтой” хэмээн өгүүлэв. Волкер цааш нь “Үүний улмаас Оростой дипломат болон эдийн засгийн харилцаагаа царцаасан нь Кремлийн хүсэх зүйл биш. Миний бодлоор, тэд өөрсдөө тооцоо хийж, шийдвэрээ гаргах ёстой” хэмээсэн юм. Тэрбээр Орос улс 2014 онд Украинаас эзлэн авсан Крымыг буцааж өгөх хүртэл хориг үргэлжлэх болно гэжээ.

Оросын тал Украины тогс шийдвэр болон Атлантын холбоотнуудын хоригийн талаарх эв нэгдэлд гайхсан байж магадгүй гэж ноён Волкер үзэж байна. Түүний бодлоор Трамп болон Францад Макрон



сонгогдсоны дараа Атлантын холбооны бэх батыг Кремль шалгахыг оролдсон аж. “Гэвч эв нэгдэл өөрчлөгдөөгүй тул тэд үүнийг тооцож үзэх ёстой” гэж мэдэгджээ. Америкийн

тусгай элч саяхан Украины зүүн нутагт очиж үзсэнийхээ дараа тэнд “халуун дайн” болж байна гээд Оросын удирдлагын доорх салан тусгаарлагчид гал зогсоох гэрээг байнга зөрчиж байгааг

шүүмжилсэн. Тэрбээр Орос, Украин, Европын албныхантай уулзаад Минскийн гэрээ юунд ч хүргээгүйг онцлов. АНУ энхийн үйл явцад түлхэц өгөх зорилготой гэнэ. Гэвч тэрбээр мухардлаас

гарахад Москва үүрэг хүлээх ёстой гээд “Украины зүүн нутагт Оросын хүчин байгаа. Тэднийг гаргах ёстой” хэмээн шаардсан байна.



Технологийн аваргуудад зохицуулалт хэрэгтэй

Рана Орухар

1990-ээд оны дундуур арилжааны интернет дөнгөж эхэлж байх үед технологийн компаниудын нотолж байсан нэг зүйл бий. Энэ нь бусдын үйлдлийг идэвхгүй дамжуулж, тэдний үйл ажиллагаа, үзэл бодлыг түгээхэд туслах боловч үүндээ хариуцлага хүлээхгүй байх юм. Уг санаа гараашинд бизнесээ эхлэгчид мессеж, чат буюу хайлтын систем нэвтрүүлэх үед тэднийг зохицуулах, хэрэглэгчдийн үйлдэлд хариуцлага хүлээлгэх хуулийн болон эдийн засгийн нөхцөл бүрдээгүй байлаа. Тухайн үед үүнийг шаардсан бол интернетийн хөгжилд сөргөөр нөлөөлөх байв.

Одоо цаг үе нэгэнт өөрчлөгджээ. Facebook, Google мэтийн томоохон компаниуд бидний хийж байгаа бүхнийг ажиглаад зогсохгүй сүлжээн дэх бодлогоо идэвхжүүлж байна. Жишээ нь, Шарлотсвиллд арьс өнгөөр ялгаварлах агуулгатай хүчирхийллийн дараа Facebook, Google, GoDaddy, PayPal компани хэт барууны үзэн ядагч бүлгүүдийг платформуосоо хасгах, хориглох арга хэмжээ авсан юм. Үүнийг үг хэлэх эрх

чөлөө ба үзэн ядсан үг ярианд хэрхэн ханддагаас шалтгаалан сайшаах буюу эсэргүүцэж болно.

Гэтэл энэ бүх шуугиан дунд бизнесийн гол зарчим гээгдсэн байна. Учир нь Cloudflare-ын захирал Мэтью Принсийн дүгнэж хэлснээр барууны үзэлт Daily Stormer вебсайтыг олон нийтийн шахалтаар хэрэглэгчдийн сүлжээнээс хасахад тус компани өөрийн тунхагласан бодлогын эсрэг зүйл хийжээ. Ноён Принс уг шийдвэрийн талаар “Надад муу сэтгэгдэл төрсөн учир би хэн нэгнийг интернетэд орохыг нь хориглолоо гэж бодъё. Хэнд ч ийм эрх мэдэл байх ёсгүй” хэмээв.

Харин технологийн хүчирхэг компаниуд үүнийг чадаж байна. АНУ-д гэхэд л тэдэнд тусгай эрх олгосон тул бизнесийн бусад салбарт компаниудын өмнө тулгардаг хуулийн хэрэгжилт тэднийг тойрдог. Энэ нь дэлхийн хамгийн хүчирхэг аж үйлдвэрт хэдэн тэрбумаар тооцогдох корпорацийн хөнгөлөлт болж байна. Мэдээллийн шударга байдлын тухай хуулийн 230 зүйлд хэрэглэгчдийн хууль бус үйлдэл ба контент технологийн компаниудад хамаарахгүй байхаар тусгажээ. Тэд уг

заалтыг үргэлжлүүлэхийн тулд асар их мөнгө, хүчин чармайлт зарцуулсан.

Гэвч уг хуулийг хүчирхэг улстөрчид эсэргүүцэж эхэллээ. Сенат дахь хоёр намын гишүүдээс бүрдсэн бүлэг бэлгийн зорилготой хүний таймаанд санаатайгаар тусалсан компанийг 230 дугаар заалтаас хасаж, хариуцлага ногдуулах заалтын дархлааны бодлого оруулаад асуудал шийдэгдэхгүй гэж үздэг. Тэд эрүүгийн хуулийг чангатгах гэх мэт өөр арга замыг санал болгов.

Тухайлбал, Facebook, Google зэрэг томоохон сүлжээнүүдийг төлөөлдөг Интернетийн холбооны хэвлэлийн төлөөлөгч Ноа Теран “Интернетийн салбарынхан хүний наймааг зогсоохыг хүсэж байгаа. Гэхдээ хууль ёсны интернет үйлчилгээний үндэс болсон хуульд өөрчлөлт оруулалгүй шийдэх арга зам бий” хэмээн онцолсон юм.

Ийм дүрэм журам ямар байх ёстой талаар маргаан идэвхижиж байна. Фордхамын их сургуулийн хуулийн профессор Оливер Силвэйн технологийн шинэчлэлийн бизнес загвар болон хүчин чадал өөрчлөгдөж байгаа тул хууль нь бас өөрчлөгдөх ёстой гэжээ. Тэрбээр “Одоогийн ертөнцөд 230 дугаар заалтын дархлааны бодлого тохиромжгүй. Томоохон технологийн компаниуд өөрсдийн ашиг тусын тулд хэрэглэгчийн бүх төрлийн мэдээлэл цуглуулж чадаж болсон” хэмээн онцлов. Түүний бодлоор хуулийг өөрчилж, интернетийн үйлчилгээний компаниуд идэвхгүй дамжуулагч гэдэг нь тогтоогдсон тохиолдолд тэднийг гуравдагч этгээдийн онлайн үйлдлийн хариуцлагаас чөлөөлөх ёстой аж.



Мумбайн цэнхэр ноход бохирдлын гэрч болсон нь

Саймон Мунди

Мумбай хотын зүүн хойно орших аж үйлдвэрийн Таложа дүүргийн гудамжинд тэнэмэл ноход гүйдэх нь элбэг. Гэвч зарим нохой цэнхэр өнгөтэй болсныг харсан байгаль хамгаалагчид түгшүүрийн харанга дэлдэв. Энэ нь хорт утаа ялгаруулалтын стандарт зөрчсөнөөс үүссэн гэж үзэж байна. Цэнхэр нохдын зургийг авч, нийгмийн сүлжээгээр тараасан Арати Чаухан “Аж үйлдвэрийн бүсэд агаарын бохирдол хэтэрсэн ч засаг захиргаа үл тоож байна. Бурхан уг асуудалд анхаарал татахын тулд цэнхэр нохдыг ашиглажээ” хэмээв.



Ноход Ducol Organics хэмээх будаг, хуванцар үйлдвэрлэгчийн хашаагаар тэнэж явсаар ийм болсон аж.

Гуравдугаар сард Утгараханд Мужийн шүүх ариун Ганга болон Юмина мөрнүүдэд үйлдвэрийн хаягдал, бохир цутгахаас хамгаалахын тулд “амьд биет” хэмээн зарласан билээ.

Ducol үйлдвэр зогсож, хоёр хамгаалагч үлдсэн ч цоожтой хаалганы цаанаас химийн бодисын эхүүн үнэр ханхийнэ. Мумбайн агаарын хяналтын зөвлөлийн ажилтан Анил Мохекар “Бид аж үйлдвэрийн бүсэд буруу ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй. Зөрчил илэрвэл үйлдвэрийг нэн даруй хаадаг” гээд сүүлийн 15 хоногт таван үйлдвэр хааснаа мэдээлэв. Гэвч байгаль хамгаалагчид олон

дутагдсанаас үйлдвэрийн бохирдлыг цэвэршүүлэлгүй голын усанд урсгадаг байна. Ийм байдал загасчдын амьжиргааг сүйтгэхээс гадна тунасан бохир дээр цугласан ялаа, шумуул халдвар тараах аюултайг ноён Пимента ионцлов. Аж үйлдвэрийн бохирдол Энэтхэгийн томоохон хотуудын агаарын чанарыг эрс муутгаж, аюултай түвшинд хүрч байна. Мумбай дахь Технологийн хүрээлэнгээс энэ жил явуулсан судалгаанаас үзэхэд 1995-2015 онд тус хотод агаарын бохирдлын улмаас эрт нас барагсдын тоо 32014-г хүрч 62 хувь нэмэгджээ. Мөн энэ хугацаанд хүн амын өсөлт 42

Мумбай хотын агаарын хяналтын зөвлөл уг үзэгдлийг судлаад энгийн дүгнэлтэд хүрсэн байна. Ноход Ducol Organics хэмээх будаг, хуванцар үйлдвэрлэгчийн хашаагаар тэнэж ийм болсон гэж үзсэн аж. Тус зөвлөл тэнд ашигладаг химийн бодис зайлуулах бохирдлын стандарт зөрчигдсөнийг тогтоосон тул үйлдвэрийн ажиллагааг зогсоожээ. Ийнхүү цэнхэр нохойн бодис зайлуулах бохирдлын стандарт зөрчигдсөнийг тогтоосон тул үйлдвэрийн ажиллагааг зогсоожээ. Ийнхүү цэнхэр нохойн бодис зайлуулах бохирдлын стандарт зөрчигдсөнийг тогтоосон тул үйлдвэрийн ажиллагааг зогсоожээ. Ийнхүү цэнхэр нохойн бодис зайлуулах бохирдлын стандарт зөрчигдсөнийг тогтоосон тул үйлдвэрийн ажиллагааг зогсоожээ.

Түүний хэлснээр Мумбай хот оршдог Махараштра мужид усны бага бохирдолд стандарт мөрдүүлэхэд хойрго хандсанаас шалтгаалдаг аж. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт

хувиас дээш гарчээ. Энэтхэгийн нийслэл Шинэ Дели хот дэлхийн том хотуудаас хамгийн муу агаартай гэж зарим судалгаанд дурдсан байдаг. Энд дээрх шалтгаанаар нас барагсдын тоо 48651 болж, 147 хувь нэмэгджээ. Шинэ Делийн Шинжлэх ухаан, байгаль орчны төвийн захирал Ануита Ройчоудхури “Гол бохирдуулагчид агаарын чанарын стандартыг маш муу болгож байгаа. Гэвч уг стандартыг мөрдүүлэх арга механизм алга. Хэрэгжүүлэх стратегийг үнэхээр цогцлэх шаардлагатай” хэмээн өгүүлсэн юм.



Онлайн бичлэгийн эздийг хянах алхам

Юань Ян
БНХАУ-ын Засгийн газар онлайн тайлбар бичиж буй хүмүүсийг тодорхойлох бүртгэл хөтөлхийг технологийн компаниудад үүрэг болгохоор төлөвлөв. Уг арга хэмжээ нь интернэтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хянан хязгаарлах кампанит ажлын хүрээнд хийгдэж байгаа юм.

Баасан гарагт гарсан шинэ зохицуулалтаар интернэт мессежийн үйлчилгээ эрхэлдэг бүх компани хэрэглэгчдийнхээ хэн болохыг аравдугаар сарын 1-нээс эхлэн тодорхойлж байх үүрэг хүлээв. “Онлайн тайлбарууд нь интернэт орчинд сөрөг үр дагавартай худал цуу, бохир заваан үг яриа, хууль бус мэдээлэл ихсэх нөхцөл болж байна” хэмээн БНХАУ-ын Засгийн газрын төлөөлөгч мэдэгдлээ.

Онлайн үг яриаг хязгаарлах арга хэмжээ нь энэ оны эцсээр чуулах ХКН-ын XIX Их хурлаас өмнө тус улсын удирдлагыг шүүмжлэх, муулах явдалд хяналт тавих гэсэн санаархал хэмээн улс төрийн тоймчид үзлээ. БНХАУ-ын дарга Ши Жиньпинийг Винни Пухтэй зүйрлэсэн шог яриа интернэтэд тархсаныг тус улсын технологийн компаниуд намжаах зорилгоор алдарт бамбаруушны дүрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дурдахыг хориглосон удаатай.

“Интернэт орчныг хянан цагдах хуулийн үндэс бий болчихлоо” хэмээн Бээжин дэх нэрээ дурдахыг хүсээгүй хуульч өгүүлэв.



BVM©

“Иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа онлайн мэдээллийн хэрэгсэлд заналхийлсэн арга хэмжээ. Бүгдэд маань нөлөөтэй” хэмээн Бээжинд амьдардаг түүхч Жан Лифань өгүүлэв. “Иргэдийн зүгээс эрх баригчдыг шүүмжлэх, шоолох явдлыг хязгаарлах хачин хачин арга хэмжээ авч байгаа нь Хятад оронд хүртэл хэвийн бус үзэгдэл” хэмээн тэрбээр дургүйцлээ илэрхийллээ.

Кибер орон зайг зохицуулагчид

урьд нь ч интернэт үйлчилгээ эрхлэгчдээс хэрэглэгч нараа тодорхойлох мэдээллээр хангахыг шаардаж байв. Гэхдээ энэ нь ажил хэрэг бололгүй өнгөрсөн. Жишээ нь, микробиогийн үйлчилгээ эрхлэгч дэлхийн хамгийн том компани Weibo уг шаардлагын дагуу зөвхөн VIP хэрэглэгчдээ тодорхойлдог болсон юм.

Харин энэ удаагийн зохицуулалт нь энэ оны зургадугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж

эхэлсэн Хятадын кибер аюулгүй байдлын анхны хуулийн дагуу гарчээ. Ийм ч учраас шаардлагад захирагдаагүй компаниудыг зохицуулах байгууллагууд шийтгэх болно.

Энэ сарын эхээр Хятадын кибер аюулгүй байдлын захиргаанаас (Cybersecurity Administration of China) тус улсын технологийн аваргууд - Tencent, Baidu, Sina Weibo зэрэг компанид “нийгмийн тогтвортой байдалд

заналхийлсэн” материал тарааж буй, эсэхийг илрүүлэх өргөн цар хүрээтэй шалгалт явуулсан.

“Интернэт орчныг хянан цагдах хуулийн үндэс бий болчихлоо. Кибер аюулгүй байдлын захиргаа контент хянах, зохицуулах ажлаа хийж буйгаа л ойлгуулсан хэрэг” хэмээн Бээжин дэх нэрээ дурдахыг хүсээгүй хуульч өгүүлж байлаа. “Хуучны зохицуулалтууд хүмүүсийн үг ярианд бус, онлайн үйлчилгээнд чиглэдэг байсан.

Хүмүүсийн үг яриаг хариуцах газар тодорхойгүй байлаа” хэмээн хуульч нэмж тайлбарлав.

Орчин үед гар утасны дугаар нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй байнга холбоотой байдаг болсон. Хятад орны иргэд гар утасны SIM карт худалдан авахдаа жинхэнэ овог нэрээ бүртгүүлж, шалгуулах ёстой. Тодорхой хувь хүнээс гаралтай мессежийг цагдаагийн байгууллага мөрдөх үед энэхүү мэдээллийг ашиглана. Гэхдээ SIM карт борлуулдаг аварга хар зах ч Хятадад ажилладаг.

Weibo-гийн хэрэглэгчид шинэ зохицуулалтын талаар өөр өөр байр суурьтай байна. “Бид Чин гүрний үе рүү ухрах нь уу?” хэмээн сэхээтэн, зохиолчдыг шоронд хорьдог байсан түүхэн үеийг эш татан F1023 хэрэглэгч бичжээ. “Жорлонд орохдоо нэр усаа бүртгүүлдэг болох нь ээ?” хэмээн өөр нэгэн хэрэглэгч бухимдлаа илэрхийлэв.

Qianhao нэрээр бүртгүүлсэн нэгэн “Кибер орчныг хортой, буруугаар ашиглах явдлыг ирээдүйд хянан зогсоож болно. Маш сайн хэрэг” хэмээн талархсан байх юм. “Манай интернэт хэрэглэгчдийн дийлэнх нь ХКН, Засгийн газрыг шүүмжлээд байдаггүй. Тэгэхээр айхтар хохиогч гарах нь юу л бол” хэмээн технологийн хөрөнгө оруулагчтан Beijing Forty-Two Channels Technology компанийн үндэслэгч Чюй Кай өгүүллээ.

Baidu-гийн Tieba вэб форум “Манайд нөлөөлөөд байх зүйлгүй. Бид шинэ хуульд тохируулан форумдаа шаардлагатай өөрчлөлт оруулсан” хэмээн тайлбарлав. Гэхдээ л тус форумд Financial Times-ийн сурвалжлагч жинхэнэ нэр усаа оруулж шалгуулалгүйгээр бүртгүүлж, пост бичиж болж байлаа.



Тереза Мэй хэт өндөр цалинтай боссуудын эсрэг тэмцэнэ



BVM©

Жорж Паркер

Компанийн захирлуудад хэт өндөр цалин олгох нь “Капитализмын хүлээн авч болшгүй дүр төрх” хэмээн шүүмжилсэн Тереза Мэй асуудлыг шийдвэрлэх багц арга хэмжээг энэ долоо хоногт танилцуулахаар төлөвлөж байна.

Боссуудын “Хэт их цалинтай мөртлөө хариуцлага хүлээх чадваргүй” цөөнх хэсгийн зарим үйлдэл нь бизнесийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж, “Манай орны нийгмийн өнгө төрх”-д аюул учруулж байна хэмээн хатагтай Мэй шүүмжиллээ.

Консерватив намаас парламентад сонгогдсон нэгэн гишүүн хатагтай Мэйг “Анти-капитализмд сэтгэн хаяж байгаа юм” хэмээн өнгөтөлөв. Гэхдээ Ерөнхий сайдын дайралт нь хэт өндөр цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх аядуу саналаа хаацайлах оролдлого ч байж болзошгүй.

Сангийн сайд Филип Хэммонд болон бизнесийн бүлгийнхний шахалтад бууж өгсөн хатагтай Мэй компанийн Удирдах зөвлөлд ажилчдыг оролцуулах төлөвлөгөөнөөсөө татгалзсан.

Мөн хэт өндөр цалин олгодог явдалд саад хийх үүднээс хувьцаа эзэмшигч нарт илүү эрх

мэдэл олгох төлөвлөгөө нь анхныхаасаа суларлаа.

Хэт өндөр цалинтай боссуудын эсрэг арга хэмжээ нь хатагтай Мэй 2016 оны долдугаар сард Даунинг стрийтийн 10-т шилжмэгцээ дэвшүүлсэн, консерватив намын дүр төрхийг “ажилчдын нам” болгон өөрчлөх төлөвлөгөөнийх нь бүрдэл. Гэвч хатагтай Мэйг сонгуулийн кампанийнхаа үеэр эдийн засаг чандаагүй хатагтай компанийн цалингийн шинэ тогтолцоо үүсгэх төлөвлөгөө хэрэгжих боломж тааруу.

Парламент дахь консерватив намын гишүүн, урьд нь хатагтай Мэйг бодлогын зөвлөх байсан Жорж Фримэн түүнийг “Анти-капитализмд сэтгэн хаяж байна” хэмээн шүүмжлээд зогссонгүй. Тэрбээр Ерөнхий сайдын сонгуулийн кампани нь “Британийн ажил хэргийн байгууллагуудад халтай” өн-

гөрсөн талаар тайлбарласан юм.

Харин хатагтай Мэй ням гарагт Daily Mail-д нийтлүүлсэн хариундаа урьдны консерватив Ерөнхий сайд Эдвард Хитээс бизнесийн магнат Тайни Роулэндийг “Капитализмын хүлээн авч болшгүй нүүр царай” хэмээсэн тодорхойлолтыг эш татав. “Сүүлийн хэдэн жилд та бид капитализмын хүлээн авч болшгүй нүүр царайг дэндүү олон хардаг боллоо. Компаниудын цөөн зарим нь та бидний хүсэн хүлээж буй эрхэм дээд стандартын хаана нь ч хүрч чадаагүй байна” хэмээн хатагтай Мэй бичжээ.

Ийм боссуудын зарим нь “Ажилчдыг хамгаалахын тулд бий болгосон хууль журмыг зориуд санаатай зөрчдөг. Нөгөө хэсэг нь компанийн хүч бололцооноос хэтэрсэн цалинг боссуудад олгох гэж буйд түгшсэн хувьцаа эзэмшигч нарыг үл тоодог” хэмээн Ерөнхий сайд үзэж байна.

Хариуцлага хүлээх чадвартай бизнес эрхлэгч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ойлг гутаадаг ийм үйлдэл нь “бизнесийг жигшигч” Хөдөлмөрийн намын эрс байр суурь баримтлагчдад далим болж буй талаар хатагтай Мэй үргэлжлүүлэн бичжээ.

Ерөнхий сайд бизнесийн бүлгийнхэнтэй жил орчим зөвлөлдсөний эцэст гаргаж буй компанийн засаглалыг шинэчлэх төлөвлөгөөнийхөө нарийн ширийн зүйлсийг мягмар гарагт танилцуулна. Тэрбээр ерөнхий захирлуудын цалинг ажилчдын дундаж цалинтай жишсэн харьцааг ил тод нийтлэх шаардлагыг компаниудад тавих замаар бизнесийн удирдлагад шахалт үзүүлэхээр төлөвлөж байна.

Мөн тодорхой компанийн хувьцааны 20-иос доошгүй хувийг эзэмшигчдийн зүгээс захирлуудын цалинтай холбоотой эсэргүүцэл гарч байсан, эсэхийг бүртгэж байх журам ч уг шинэчлэлийн төлөвлөгөөнд багтаж байна.



Бараа, үйлчилгээний татварыг эсэргүүцэн жагссан Энэтхэгийн бөс даавууны салбарын ажилчид, зургадугаар сард.



BVM©

Энэтхэгийн татварын шинэ тогтолцоонд бэрхшээл үүслээ

Киран Стэйси

Энэтхэгийн сая бизнес эрхлэгч долдугаар сард төлөх ёстой татвараа төлж чадсангүй. Татварын шинэ тогтолцоонд дагсан зохицохоор хичээж байгаа үйл олон компаниас учруулж буй аварга ачааллыг тус улсын татварын шинэ тогтолцоо дааж дийлсэнгүй.

Татвар төлөгчид Энэтхэг орны бараа, үйлчилгээний татварыг хурааж, бүртгэх үүрэгтэй онлайн платформтой холбогдуулан интернэт холболт удаан, татварын мэдүүлэг бөглөх зай дэндүү бага гэх мэт түг түмэн гомдол тоочиж байна.

Эдгээр гомдол нь Энэтхэгийн татварын шинэ тогтолцоонд бэрхшээл тулгарсны илрэл. Энэтхэг орны удирдлага арван жил маргалдаад гуравхан сарын дотор боловсруулсан төлөвлөгөөний дагуу долдугаар сард татварын шинэ тогтолцоо нэвтрүүлсэн юм. Уг тогтолцоо нь муж улс бүрт тусдаа хэрэгждэг байсан салангид олон татварыг нэгтгэж, Энэтхэг орныг анх удаа нэгдмэл зах зээл болгон хувиргаж өгчээ.

GST буюу бараа үйлчилгээний татвар нь Ерөнхий сайд Нарендра Модигоос Энэтхэгийн эдийн засгийг өөрчлөн шинэчлэх төлөвлөгөөний салшгүй бүрдэл. Гэвч шинэ тогтолцоог хэт богино хугацаанд бэлтгэлгүй нэвтрүүлсэнээ үүдэн төвөг чирэгдэл ихсэж, уг тогтолцоо түшиглэдэг IT платформын эмзэг

тал тодорч буйг шүүмжлэгч нар өгүүлж байна. Шинэ тогтолцоо хэрэгжиж буй эхний шатанд ийм олон бэрхшээл үүсэх нь ноён Модигийн эдийн засгийн шинэчлэлд эргээд сөрөг нөлөөтэйг шүүмжлэгч нар анхааруулсан юм.

Татвар хураах онлайн платформ ажиллуулж буй GST Network-оос өнгөрсөн лхава гарагт мэдээлсэнээ үзвэл Энэтхэгийн хоёр сая иргэн бараа, үйлчилгээний татварыг интернэт ашиглан төлжээ. Үйлчлүүлэгчдийн тал хүрэхгүй хувь нь төлбөрөө амжилттай хийж байгаа талаар нягтлан бодогч нар мэдээлж байна.

“Үйлчлүүлэгчдийн маань ихэнхэд нь хүндрэл тулгарч байгаа. Гол нь хийчихсэн төлбөрийг татварын систем боловсруулж дийлэхгүй байгаад хүмүүс гомдолтой байна” хэмээн санхүүгийн үйлчилгээний Ernst & Young байгууллагын Адিশек Жайн тайлбарлав.

Бараа, үйлчилгээний татвараа цагт нь төлөөгүй хүмүүсийг эрх баригчид торгохоо хойшлуулах нь зүйтэйг ноён Рагунатан анхааруулав.

Бизнес эрхлэгчид бараа, үйлчилгээний татвараа өнгөрсөн баасан гарагийн шөнө дунд гэхэд төлсөн байх ёстой байжээ. Гэтэл хүндрэлээ шалтгаалан уг хугацааг хоёр ч удаа хойшлуулсан. Мөн онлайн төлбөрийн платформ хоёр долоо хоногийн өмнө ачааллаа даалгүй гацсаныг нь сэргээжээ.

Юутай ч өнгөрсөн долоо хоногийн эцсийн байдлаар татварын онлайн тогтолцоо бүрэн тогтворжиж чадаагүй, онлайн төлбөрийн системд компаниудын программ хангамжийг холбох үүрэгтэй дигитал интерфэйс төгөлдөржиж амжаагүй хэвээр байсан юм.

“Систем одоогоор бидний тооцоолж байсан шиг ажиллаж чадаагүй байгаа ч цаашдаа сайжирна. Тогтвортой ажилладаг болгох гэвэл хэдэн сарын хугацаа шаардах бололтой” хэмээн компаниудад бараа, үйлчилгээний татвараа төлөхөд нь туслалцаа үзүүлдэг ClearTax онлайн платформ ажиллуулдаг Арчит Гупта өгүүллээ.

Бараа, үйлчилгээний татвар нь Энэтхэгийн “Макро эдийн засгийг тогтворжуулж байгаа” талаар тус улсын Сангийн сайд Арун Жайти энэ долоо хоногт мэдэгдсэн юм.



Эдийн засаг

ЭРЧИМ ХҮЧ

Илч, гэрлийн эх үүсвэрийн үнэ өсөхгүй



Засгийн газар энэ онд станцуудад нийлүүлэх нүүрсний үнийг өсөхгүй байх бодлого баримталж буй учраас цахилгаан, дулааны нэгжийн үнэд өөрчлөлт орохгүй нь. Мөн нүүрсний жижиглэнгийн үнэд ч өөрчлөлт орохгүйг болохыг албаныхан амлаж байна.

С.Батсайхан / ЗГМ©

Харин энэ онд хоёр сая тонн орчим нүүрс олборлохоор төлөвлөсөн Шивээ-Овоогийн уурхайд одоогоор 400 мянган тонны нөөц бэлэн байгааг албаныхан мэдээлэв. Дархан-Уул аймагт байрлах Шарын гол уурхай нийлүүлэлтэд зориулан 200 мянган тонныг нөөцлөөд байна. Өөрөөр хэлбэл, энэ долоо хоногийн байдлаар төвийн бүсийн гол эх үүсвэр болсон гурван уурхайд 1.2 сая тонн нүүрсний нөөц байгааг Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Болдхүү мэдээллэв. Одоогоор 800 орчим вагон нүүрс тээвэрлэж байгаа бөгөөд энэ тоог 1000-д хүргэхээр салбарын яам Улаанбаатар төмөр зам хувь

нийлүүлсэн нийгэмлэгтэй яриа, хэлэлцээ эхлүүлжээ.

Багануурын уурхай 600 сая тонн нүүрс олборлож, бэлтгэсэн байна

Үүнээс гадна цахилгаан, дулааны станцуудад нүүрсний нөөц бий. Төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээний 67.3, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 60.3 орчим хувийг дангаар хангадаг ДЦС IV гэхэд нүүрсний 13 хоногийн нөөцтэй.


Тэгвэл хүчин чадлаа өргөтгөөд буй ДЦС III түүхий эдийн 8-9, ДЦС II нүүрсний 10 хоногийн нөөцтэйгээр өвлийн бэлтгэлээ хангаж байна. Тэрчлэн "Амгалан" ДЦС" нүүрсний захиалгаа өгчихөөд байгаа аж. Одоогоор дулааны цахилгаан станцуудын нүүрсний нөөц дунджаар 10 хоногт хэлбэлзэж байгаа ч энэ хугацааг арваннэгдүгээр сарын 1 гэхэд 20 хоногт хүргэхээр зорьж байна.

Жилийн жилд дулаан, цахилгааны үнэ, цаашлаад түүний түүхий эд болох нүүрсний ханш олон нийтийн анхаарал татдаг. Учир нь олон жилийн турш уурхайнууд олборлолтын зардлаасаа хямд үнээр станцуудад нүүрс нийлүүлж ирсэн. Тодруулбал, нэг уурхай тонн нүүрсийг

32 мянган төгрөгөөр олборлож түүнийгээ 29.5 мянган төгрөгөөр худалддаг. Энэ нь төрийн өмчит нүүрсний уурхайнуудын санхүүгийн чадавхид саар үзүүлэлт дагуулж, алдагдал хүлээх нэг шалтгаан болдог юм. Тиймээс нүүрсний үнийг өсгөх сонирхол уурхайнуудад бий. Өнгөрсөн онд гэхэд цахилгаан, дулааны станцуудад нийлүүлсэн нүүрсний үнийг тонн тутамд нь 1000 төгрөгөөр өсгөж байв. Тэгвэл энэ онд Засгийн газар үнийг хадгалахаар төлөвлөж буй. Өөрөөр хэлбэл, станцуудад нийлүүлэх нүүрсний үнэ өсөхгүй учраас цахилгаан, дулааны нэгжийн үнэд өөрчлөлт орохгүй нь. Мөн нүүрсний жижиглэнгийн үнэд ч өөрчлөлт орохгүйг албаныхан амлаж байна.

Үүнээс гадна хэтийн нийлүүлэлтэд санаа тавих зарим зүйл бий. Тухайлбал, нийслэлчүүдийн эрчим хүчний хэрэглээ жилээс жилд нэмэгдсээр байгаа. Энэ онд гэхэд 100 орчим киловатт цагаар өсчээ. Тиймээс өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, түүнийг эх үүсвэрийг бэлтгэх шаардлага бий. Эрчим хүч, дулааны энэ их хэрэгцээг хангахын тулд ДЦС III-ын хүчин чадлыг 250 мегаваттаар өргөтгөхөөр төлөвлөсөн юм. Энэ өргөтгөл ашиглалтад орсноор ДЦС III-т ойролцоогоор нэг сая тонн нүүрсний хэрэглээ үүснэ гэсэн тооцоо гарчээ. Тиймээс ирээдүйн үйлдвэрлэлийн түүхий эдийг одооноос бэлтгэхээс өөр аргагүй. Иймд одооноос нэмэлт нийлүүлэлт хийх нүүрсний уурхайнуудыг судалж эхэлжээ. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК



ЗГМ ТОВЧХОН

» АШИГ

36.1

Тэрбум төгрөг. МИК хувьцаат компанийн цэвэр ашиг энэ оны хоёрдугаар улиралд өмнөх оны мөн үеэс 18 хувиар өсөж, 36.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

» БАНК САНХҮҮ

3.1


Их наяд төгрөг. Мобайл банкаар хийсэн гүйлгээ энэ оны эхний улиралд 3.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өссөн болохыг Монголбанк хөдөлгөөнт банкны тайландаа дурджээ.

» ХУВЬЦАА

57.5

Хувь. "Mongolian Mining Corporation"-ийн хувьцааны ханш нэг сарын хугацаанд 57.5 хувь өссөн байна. Тус компани оны эхний хагаст 250-375 сая ам.долларын ашиг олох төлөвтэй байгаа нь эерэгээр нөлөөлжээ.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Монголын хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс 950.22 нэгж болж 0.07 хувиар буурлаа.

4.7

Тэрбум төгрөг. Монголын хөрөнгийн биржийн өнгөрсөн долоо хоногийн арилжаагаар нийт 4.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ. Өөрөөр хэлбэл, өдөрт дунджаар 948 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

» АРИЛЖАА

1.6

Хувь. "Ремикон" компанийн хувьцааны ханш даваа гарагт хамгийн өндөр буюу 1.6 хувиар өслөө. Харин "Багануур" компанийнх 2.29 хувиар унав.

» ТҮҮХИЙ ЭД

1

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш нэг хувиар буурч, баррель нь 47.39 ам.долларт хүрэв.

» ДЭЛХИЙД

25


Хувь. BHP Billiton Канад дахь поташийн уурхайн 25 хувийг хоёр тэрбум ам.доллараар худалдана.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2434.74
Евро	2903.67
Япон иен	22.31
ОХУ рубль	41.51
БНХАУ юань	366.62
БНСУ вон	2.17

УУЛ УУРХАЙ

"Prophecy Development" хаалттай хувьцаа гаргалаа



Т.Элса Шинжээч

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Prophecy Development" компани хөрөнгө оруулагчдад үйл ажиллагаагаа шинэчлэн танилцууллаа. Тус компани 5.4 сая ширхэг хувьцаа нээлттэй арилжаалж байгаа юм. Сүүлийн 52 долоо хоногийн дунджаар нэгж хувьцааны ханш нь 1.6-7.2 канад долларын хооронд хэлбэлзэж байна. "Prophecy Development"-ийн гүйцэтгэх захирал бөгөөд тэргүүн Жон Ли нийт хувьцааны 19 хувийг, "Arogee Silver" компани есөн хувийг нь эзэмшиж байгаа аж. 2017 онд тус компани Хойд Америкт ванадын төслүүдийг худалдаж авах, өргөжүүлэхэд төвлөрч байна. Долдугаар сарын 31-ний байдлаар ванадын ислийн ханш

2016 оныхоос 500 хувиар өсөөд байгаа юм. Сэргээгдэх эрчим хүчний фермүүд нэмэгдэхийн хэрээр ванадын редоксоор хийсэн зай хураагуурын эрэлт нэмэгдсэн нь үүнд нөлөөлсөн байна. Тиймээс тус компани энэ салбарыг сонирхож эхэлжээ. Үүний зэрэгцээ "Prophecy Development" компани өнгөрсөн баасан гарагт 3.1 сая ам.долларын хөрөнгө татах зорилгоор 888 мянган нэгж хувьцааг хаалттай хүрээнд гаргалаа. Компани энэ хөрөнгийг уул уурхайн төслүүддээ эргэлтийн хөрөнгө байдлаар ашиглахаар төлөвлөж байна. "Prophecy Development" компани Монголд Улаан Овоогийн эрчим хүчний нүүрсний уурхайд олборлолт хийж байгаа бөгөөд 0.6 тэрбум тонн нүүрсний баталгааг нөөцтэй "Чандгана" төсөл тус компанийн мэдэлд байна.

Эдийн засаг

ТЭЭВЭР

Онлайнаар тийз захиалал

Хандлага нэмэгдсэн

Агентлаг

бий болсноор

тасалбарын үнэ

хямдарсан

Г.Байгал
@baigalZGM

“Эйр Транс” компанийн ерөнхий захирал Т.Чулуунхүүтэй ярилцлаа.

Сүүлийн жилүүдэд ажиглагдаж буй Монголын эдийн засгийн хүндрэл онгоцны тийз захиалгад хэрхэн нөлөөлж байна вэ?

Сүүлийн 2-3 жилд түүхий эдийн үнэ унаснаас манай эдийн засаг хүндрлээ. Үүнээс үүдэн хүмүүсийн худалдан авах чадвар муудсан. Гэхдээ эргээд сэргэж буй нь мэдрэгдэж байна. Монголд олон улсын чиглэлд найман авиа компани нислэг үйлдэж байгаа. Авиа компаниуд нислэгийнхээ тоог дураараа нэмдэггүй. Ашиг, алдагдлаа тооцохоос гадна хоёр улсын Засгийн газрын гэрээ нөлөөлнө. Ер нь нислэгийн суудал дүүргэлт 70 хувиас дээш байж ашиг олдог. Тиймээс нислэг, суудлыг нарийн тооцох хэрэгтэй. Солонгосоор жишээ авъя. БНСУ-ын чиглэлд нислэг үйлддэг авиа компаниуд ачааллаа дийлэхгүй байна. Ялангуяа зуны улиралд хоёр компани Сөүлийн чиглэлд долоо хоногт нийт 22 удаа нислэг үйлдэж, зуны гурван сард талдаа 60 мянга орчим зорчигч тээвэрлэдэг. Үүний тал нь жуулчид гэж үзвэл БНСУ-аас 30 мянга хүрэхгүй жуулчин ирж байна гэсэн үг. Ялангуяа, долоо болон наймдугаар сард БНСУ-д ид

халах үеэр тус улсаас Монголыг зорих хүсэлтэй иргэдийн тоо нэмэгддэг. Гэвч нислэгийн суудал олдоггүй. Аялал жуулчлалд саад болж буй олон сорилтын нэг нь онгоцны суудлын хүрэлцээ.

Монголд тийз захиалгын үйлчилгээг анх “Эйр Транс” компани нээсэн гэж салбарынхан ярьдаг юм билээ. Зуучийн агентлагтай болсноор зорчигчид ямар давуу тал бий болов?

Одоогоос 20 жилийн өмнө онгоцны тийз захиалгын анхны агентлагийг эх орондоо байгуулж байлаа. Компани байгуулахаасаа өмнө би МИАТ компанийн Бээжин дэх салбарт ажиллаж байсан юм. Тухайн үед манай зорчигчид тийзээ авиа компаниудаас худалдаж авдаг байв. Харин Бээжинд тийз зуучийн агентлагууд үйлчилдэг байлаа. Тиймээс энэ үйлчилгээг Монголд нэвтрүүлэхээр шийдэж, МИАТ-ийн маркентгийн албанд ажиллаж байсан хамтрагчтайгаа нэгдэн “Эйр Транс”-ыг байгуулсан. Одоо Монголд Олон улсын иргэний нисэхийн байгууллага буюу IATA-гийн гишүүн 13 агентлаг үйл ажиллагаа явуулж, нийт 300-гаад хүн ажиллаж байна.

Тийз захиалгын агентлаг бий болсноор үйлчилгээний чанар сайжирч, тасалбарын үнэ хямдарсан. Өмнө нь МИАТ-ийн онгоцоор Бээжинд очоод цаашаа Сингапурыг зорих гэж буй хүн МИАТ-аас дахин Сингапурын тийз авахад өндөр үнэтэй байсан. Учир нь тухайн үед авиа компаниуд тийзийг хоорондоо өндөр үнээр борлуулдаг байсан юм. Харин агентлагууд үүнийг өөрчилж, авиа компани тус бүртэй гэрээ байгуулж, хямд үнээр нийлүүлэх болсон. Бид иргэний нисэхийн тээврийн компаниудын туслан гүйцэтгэгч гэж хэлж болно.

Буянт-Ухаад
дотоодын
онгоцоо
буулгаж
болохгүй. Бүх
онгоцоо шинэ
буудлаасаа
хөөргөж, өрийг
нь төлж дуусгах
хэрэгтэй



Б.Ганбаяр / ЗГМ ©

Зорчигчид хүссэн цагтаа суудлаа авч чадахгүй байна гэж сэтгэгдэл цахим ертөнцөд харагддаг. Зуучийн агентлагууд энэ боломжийг бүрэн олгохгүй байна уу?

Манай зорчигчид нислэгийн соёл, боловсролд хэвшээгүй. Тухайлбал, Монголоос явахдаа яаж ийгээд суудлаа олоод, тийзээ захиалчихдаг. Харин буцах өдрөө нарийн тооцдоггүй. Гэтэл зорьсон хэрэг нь бүтэж, гэнэт буцахаар болоход тийз олдохгүй байна гэж зарим нь авиа компани, агентуудыг загнаана. Хэрэв хүссэн цагт нь суудал олдохгүй бол бухимдаад, түүнийг нийгмийн сүлжээгээр цацах тохиолдол ч бий. Уг нь бид тийз захиалахаас өмнө сануулж, буцах өдрөө нарийн тооцохыг зөвлөдөг.

Тийзний үнийг хямдруулах боломжтой гэж зарим хүн ярьдаг. Үүнд таны байр суурь ямар байна вэ?

Тийз борлуулагч агентлагууд үнэ тогтоох эрхгүй. IATA-гийн агентлагуудын баримтлах ёстой зарчим бол авиа компаниудын

зарласан үнээр тийз борлуулна. Авиа компани тийс хийсэн гэрээнийхээ дагуу бид онгоцны тийзийн үнэд нэг төгрөг ч нэмэх эрхгүй. Харин хасч болно.

Долоон жилийн өмнө IATA-гийн гишүүн агентлагууд агаарын тээврийн компани тус бүртэй гэрээ байгуулж, тооцоо хийдэг байлаа. Жишээлбэл, манайх 20 авиа компанитай хамтран ажилладаг бол төдий тооны компанитай тусад нь тооцоо хийж, мөнгө шилжүүлнэ. Харин 2010 оны эхээр Монгол Улс IATA-гийн BSP шинэ программд нэгдсэнээр илүү хялбар болсон. Өөрөөр хэлбэл, авиа компаниудтай бид биш IATA гэрээ байгуулна. Мөн давхар биднтэй байгуулж, авиа компани болон агентлагуудыг хооронд нь холбох болсон. Ингэснээр 20 авиа компанид төлөх төлбөрөө багцлаад долоо хоногт нэг удаа IATA руу шилжүүлдэг. Үүнийг нь IATA хүлээн аваад, авиа компаниудад хуваадаг. Үр дүнд нь бидний болон агаарын тээврийн компаниудын ажил хөнгөрсөн.


Энэ зах зээлийн ирээдүйг та хэрхэн төсөөлж байна вэ?

Одоо байгаа агентлагуудын тоо хангалттай санагдаж магадгүй. Гэхдээ Монголын эдийн засаг байнга өнөөдрийнх шиг байхгүй. Ирэх жилүүдэд өсөх нь ойлгомжтой. Энэ хэрээр агаарын тээвэрээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ. Тиймээс үүнд бэлэн байхын тулд IATA-гийн агентлагуудын тоог өсгөх хэрэгтэй гэж боддог. Агентлаг байгуулах нь тийм ч хэцүү биш. Харин менежментийг нь хийж, хэрэгжүүлэх боловсон хүчин бэлтгэх нь хамгийн чухал.

Тийз борлуулагч агентлагууд үнэ тогтоох эрхгүй

Монголыг чиглэх жуулчдын тоог тогтмол нэмэхийн тулд юу хийх шаардлагатай вэ?

Алтны ханш өслөө



Алтны спот ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

Олон улсын зах зээлд унци алтны ханш 0.5 хувиар чангарч, 1297 ам.долларт хүрлээ. АНУ-ын Техас мужийг нөмөрсөн харви хар шуурга тус улсад багагүй эрэдэл учруулж байгаа нь хөрөнгө оруулагчид алт руу хошуурах шалтгаан болсон. Тиймээс алтны ханш сүүлийн хоёр өдөр дараалан өслөө. Харин шар металлтай урвуу

хамааралтай ам.долларын ханш суларч байна.

“Bloomberg”-ээс голлох валютуудтай жигнэн тооцдог ам.долларын спот ханш 2.5 жилийн доод цэгт хүрээд байна. Тухайлбал, ам.доллартай харьцах еврогийн ханш 0.5 хувиар өсөж, 1192 ам.долларт хүрлээ. Ингэснээр хоёр жилийн дээд цэгт хүрч байна. [ЗГМ]

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	66.5	▼ -1.23%	8/28/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.017	▲ +13.33%	8/28/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	12.375	▼ -1%	8/28/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.019	▼ -5%	8/28/2017
GUILD FORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	8/28/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.32	▼ -4.87%	8/28/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.87	▼ -1.78%	8/28/2017
SOUTHGLOBE RESOURCES	SGQ	TSX	CAD	0.23	▼ -2.17%	8/28/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.195	▲ +2.63%	8/28/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.57	▼ -3.39%	8/28/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1296.58	▲ +0.42%	8/28/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	984	▲ +0.5%	8/28/2017
МӨНГӨ	SIA	унци	17.24	▲ +0.63%	8/28/2017
ЗЭС (СОМEX)	HGA	фунт	309.45	▲ +1.24%	8/28/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	74.97	▼ -0.03%	8/28/2017
WTI ТОС	CLA	баррель	47.38	▼ -1.02%	8/28/2017
БРЕНТ	COA	баррель	52.31	▼ -0.19%	8/28/2017
БЕНЗИН	XBA	галлон	173.98	▲ +4.39%	8/28/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.895	▲ +0.1%	8/28/2017
НҮҮРС (NУMEK)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	8/28/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	94.9	▼ -0.58%	8/28/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.140	▲ +0.07%	8/28/2017
БУДАА	RRA	центнер	12.73	▲ +0.16%	8/28/2017
БУУДАЙ	WA	бушель	433.25	▼ -0.46%	8/28/2017
КАКАО	CCA	тонн	1933	▲ +2.01%	8/28/2017
КОФЕ	KCA	фунт	1.314	▲ +2.74%	8/28/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

МЭДЭЭЛИЙН ЧАНАР АМЖИЛТЫН ҮНДЭС

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 7609293 support@ism.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	451.79	▲ 0.66%	8/28/2017
ГОВЬ ХК	GOV	14800	▼ -1.86%	8/28/2017
МАХИМПЕКС ХК	MMX	2400	◄ 0%	8/28/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	21300	▼ -0.93%	8/28/2017
СҮҮ ХК	SUV	165	▼ -0.32%	8/28/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	22100	▼ -1.34%	8/28/2017
БАГАНУУР ХК	BAN	2003	▼ -2.29%	8/28/2017
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	37000	◄ 0%	8/28/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	85.2	▲ 0.22%	8/28/2017
ХӨХ ГАН ХК	HGN	80	▲ -0.06%	8/28/2017
ЖЕНКО ТУР БЮРА ХК	JTB	61.68	▼ -0.52%	8/28/2017
РЕМИКОН ХК	RMC	41.77	▲ 1.56%	8/28/2017
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2440	▲ 0.08%	8/28/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2100	◄ 0%	8/28/2017
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	8065	▲ 1.38%	8/28/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	COMP	6265.644	-5.68	▼ -0.09%	8/28/2017
DAX INDEX	DAX	12097.31	-70.63	▼ -0.58%	8/28/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15055.99	-20.17	▼ -0.13%	8/28/2017
S&P/ASX 200	ASS1	5709.892	-33.97	▼ -0.59%	8/28/2017
S&P 500	INX	2443.05	+4.08	▲ +0.17%	8/28/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3362.652	+31.13	▲ +0.93%	8/28/2017
TOP 20	MSETOP	15546.47	-19.91	▼ -0.13%	8/28/2017
FTSE 100	UKX	7401.46	-5.6	▼ -0.08%	8/28/2017
HANG SENG	HSI	27855.37	+7.21	▲ +0.03%	8/28/2017
NIKKEI 225	NKY	19449.9	-2.71	▼ -0.01%	8/28/2017